



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 21 (306)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Төрийн албан ёсны хэлний тухай*
- *Шуудангийн тухай*
- *Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2003 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2003 оны зургадугаар сарын 4

№ 21 (306)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

298.	Төрийн албан ёсны хэлний тухай	(2003-5-15-ны хууль)	482
299.	Шуудангийн тухай	(2003-5-15-ны хууль)	484
300.	Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	(2003-5-15-ны хууль)	489
301.	Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	(2003-5-15-ны хууль)	490
302.	Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	(2003-5-15-ны хууль)	490
303.	Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай	(2003-5-15-ны хууль)	491
304.	Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	(2003-5-15-ны хууль)	500
305.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	(2003-5-15-ны хууль)	500
306.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	(2003-5-15-ны хууль)	500
307.	Аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	(2003-5-15-ны хууль)	500
308.	Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	(2003-5-15-ны хууль)	500
309.	Хот байгуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	(2003-5-15-ны хууль)	501
310.	Орон сууцны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	(2003-5-15-ны хууль)	501
311.	Хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	(2003-5-15-ны хууль)	501
312.	Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	(2003-5-15-ны хууль)	501
313.	Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	(2003-5-15-ны хууль)	502



314.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	(2003-5-15-ны хууль)	504
------	---	----------------------	-----

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

315.	Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого батлах тухай	Дугаар16	504
316.	Шуудангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар17	508
317.	Үндсэн хуулийн цэцийн 2003 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай	Дугаар 18	508

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

ТӨРИЙН АЛБАН ЁСНЫ ХЭЛНИЙ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

дэвсгэр дээр төрийн албан ёсны хэлнээс бусад хэлээр харилцах эрхийг үл хөндөнө.

Нийтлэг үндэслэл

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь төрийн албан ёсны хэл болох монгол хэл /цаашид "төрийн албан ёсны хэл" гэх/-ний хэм хэмжээ, нэр томъёог төрийн албан хэрэг хөтлөх, төрийн албан ёсны үйл ажиллагаанд хэрэглэхтэй холбогдсон харилцааг зохицуулах болон Монгол Улсын нэгдмэл байдлыг хангахад оршино.

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. "төрийн албан ёсны хэл" гэж орчин цагийн утга зохиолын болон аман ярианы монгол хэлийг;

2 дугаар зүйл. Төрийн албан ёсны хэлний тухай хууль тогтоомж

4.1.2. "төрийн албан ёсны хэлний хэм хэмжээ" гэж орчин цагийн монгол утга зохиолын хэлний зүй тогтол, хэл бичгийн дүрмийг;

2.1. Төрийн албан ёсны хэлний хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

4.1.3. "төрийн албан ёсны үйл ажиллагаа" гэж төр, захиргаа, нутгийн өөрөө удирдах байгууллагаас зохион байгуулж байгаа ёслолын арга хэмжээ, хурал, семинар, мэдээлэл, зөвлөлгөөн, хэлэлцээр, тэдгээрийн албан хэрэг хөтлөлт зэрэг төрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

3 дугаар зүйл. Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн үйлчлэх хүрээ

Төрийн албан ёсны хэлийг хэрэглэх

3.1. Энэ хууль Монгол Улсын төрийн албан хэрэг хөтлөлт, төрийн албан ёсны үйл ажиллагаа, сургалтын хүрээнд үйлчилнэ.

5 дугаар зүйл. Төрийн албан ёсны хэлийг хэрэглэх

3.2. Энэ хууль нь Монгол Улсын нутаг

5.1. Монгол Улсын төрийн албан ёсны үйл ажиллагаа, сургалтыг төрийн албан ёсны хэлээр



явуулна.

5.2. Монгол улсад амьдарч байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын төрийн байгууллагатай төрийн албан ёсны хэлээр харилцана.

5.3. Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон олон улсын байгууллага эх хэлээрээ Монгол Улсын эрх бүхий байгууллагад хандах бол орчуулгыг хавсаргана.

5.4. Монгол улсад аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа гадаад улсын хуулийн этгээд, төрийн бус байгууллага нь Монгол Улсын төрийн байгууллагатай төрийн албан ёсны хэлээр харилцаж, санхүү, татвар, хөдөлмөрийн холбогдолтой баримт бичгийг төрийн албан ёсны хэлээр хөтөлнө.

5.5. Монгол Улсын хуулийн этгээдийн албан бичгийн маягт, тамга, тэмдгийн бичээсийг төрийн албан ёсны хэлээр үйлдэнэ.

5.6. Энэ хуулийн 5.5-д заасан албан бичгийн маягыг гадаад хэлээр үйлдэх шаардлагатай бол төрийн албан ёсны хэлээр бичсэн үгийн доод талд гадаад үгийг бичиж, үсгийн хэмжээг багасгасан байна.

5.7. Хот, суурин газрын гудамж, талбайн нэр, хаяг, төрийн байгууллагын нэрийг төрийн албан ёсны хэлээр бичнэ. Эдгээр нэрийг англи хэлээр давхар бичиж болно.

5.8. Монгол Улсын эрх бүхий байгууллага гадаад улс, олон улсын байгууллагад тухайн улсынх нь хэлээр албан бичиг явуулахад орчуулгыг төрийн албан ёсны хэлээр үйлдэж албан хэрэгт үлдэнэ.

5.9. Олон улсын болон хоёр талын төрийн албан ёсны чанартай хурал, семинар, зөвлөлгөөн, хэлэлцээрт Монгол улсыг төлөөлөн оролцож буй этгээд гадаад хэл хэрэглэж болно.

5.10. Монгол улсаас гадаад оронтой байгуулах гэрээ, хэлэлцээрийг төрийн албан ёсны хэлээр үйлдсэн байна.

5.11. Монгол Улсын нэгдэн орох олон улсын гэрээ, конвенцийг төрийн албан ёсны хэлээр орчуулсан байна.

5.12. Энэ хуулийн 5.9-д заасан хурал, семинар, зөвлөлгөөн, хэлэлцээрийн тэмдэглэл, хэлсэн үг зэрэг албан ёсны баримт бичгийг төрийн албан ёсны хэлээр орчуулж баримтжуулна.

5.13. Бүх шатны боловсрол олгох сургалтыг

төрийн албан ёсны хэлээр явуулна. Энэ заалт үндсэн ба мэргэжлийн сургалтаа гадаад хэлээр явуулдаг сургалтын байгууллагад үл хамаарна.

5.14. Суралцагчид Монгол Улсын иргэн-ын дийлэнх олонхи нь хүн амын өөр хэл бүхий үндэсний цөөнх байвал сургалтыг тухайн хэлээр явуулж болно.

5.15. Энэ хуулийн 5.14-т заасан суралцагчдад боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан хөтөлбөрийн дагуу төрийн албан ёсны хэлний мэдлэгийг эзэмшүүлнэ. Казах иргэдэд үндэсний болон төрийн албан ёсны хэлийг зааж сургахад дэмжлэг үзүүлнэ.

5.16. Төрийн албан ёсны хэлээр гарч байгаа олон нийтэд зориулсан хэвлэл, мэдээлэл нь орчин цагийн монгол утга зохиолын хэлний хэм хэмжээ, нэр томъёог баримтална.

5.17. Төрийн албан хаагч, олон нийтийн хэвлэл, мэдээллийн ажилтан нь монгол хэлний хэм хэмжээ, нэр томъёог хэрэглэх зохих түвшний мэдлэг, чадвартай байна.

5.18. Төрийн албан ёсны хэлэнд дүйх үг, нэр томъёо байхад гадаад үг, нэр томъёо хэрэглэхийг хориглоно.

6 дугаар зүйл. Төрийн хэлний зөвлөл, түүний чиг үүрэг

6.1. Төрийн албан ёсны хэлэнд дагаж мөрдөх орчин цагийн монгол хэлний хэм хэмжээ, нэр томъёог шинжлэх ухааны үндэслэлтэй оноон тогтоох, баталж мөрдүүлэх, жигдлэн хэвшүүлэх, мэргэжлийн зөвлөлгөө өгөх, нэр томъёотой холбогдсон асуудлаар дүгнэлт гаргах чиг үүргийг Төрийн хэлний зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ хэрэгжүүлнэ.

6.2. Зөвлөлийн дарга нь соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

6.3. Зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг Засгийн газар батална.

6.4. Зөвлөл нь тодорхой чиглэлээр салбар зөвлөлтэй байж болно.

6.5. Зөвлөлөөс албан мэдээллийг тогтмол гаргана.

6.6. Зөвлөл нь төрийн албан ёсны хэлний талаар дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

6.6.1. олон улсад нийтлэг хэрэглэдэг нэр томъёог орчин цагийн монгол хэлний нэр томъёонд шинжлэх ухааны үндэслэлтэй хөрвүүлэх, утгачилан тайлбарлах;



6.6.2. мөрдөгдөж буй нэр томъёо, үг хэллэг нийгмийн болоод шинжлэх ухааны хэрэгцээ, шаардлагад хэрхэн нийцэж, хэрэглэгдэж байгаад судалгаа хийх, шаардлагатай гэж үзвэл өөрчилж, энэ талаар олон нийтэд мэдээлэх, хэвлэн нийтлэх;

6.6.3. нэр томъёог оноон тогтоох, толилох, жигдлэх, дэлгэрүүлэх, мөрдүүлж хэвшүүлэх ажилд холбогдох байгууллага, мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулах;

6.6.4. Монгол орны газар нутгийн оноосон нэрийг толилох, жигдлэх, дэлгэрүүлэх, олон улсын газарзүйн нэрийн ном бүртгэлд бүртгүүлэх;

6.6.5. төрийн албан ёсны хэлний нэр томъёоны талаар байгууллага, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх.

6.7. Зөвлөл нь ажлаа Засгийн газарт тайлагнана.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

7 дугаар зүйл. Төрийн албан ёсны хэлний тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт

7.1. Төрийн албан ёсны хэлний тухай хууль

тогтоомжийн биелэлтэд Зөвлөл хяналт тавьж, зөрчил илэрвэл түүнийг хэрхэн арилгах талаар албан ёсоор зөвлөмж гаргана.

7.2. Энэ хуулийн 7.1-д заасны дагуу гаргасан шийдвэрийг түүнийг хүлээн авсан этгээд заавал дагаж мөрдөх үүрэгтэй.

8 дугаар зүйл. Төрийн албан ёсны хэлний тухай хууль тогтоомжийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

8.1. Энэ хуулийг зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч дараахь захиргааны шийтгэл ногдуулна:

8.1.1. энэ хуулийн 5.4-ийг зөрчсөн гадаад улсын хуулийн этгээд, төрийн бус байгууллагыг 100000-250000 төгрөгөөр торгох;

8.1.2. энэ хуулийн 5.5-5.8; 5.12; 5.15; 5.16-г зөрчсөн Монгол Улсын эрх бүхий төрийн байгууллага, хуулийн этгээдийг 70000-250000 төгрөгөөр торгох;

8.1.3. энэ хуулийн 7.1-д заасан шийдвэрийг зөрчсөн иргэнийг 5000-50000, албан тушаалтныг 30000-60000, хуулийн этгээдийг 50000-250000 төгрөгөөр торгох;

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

ШУУДАНГИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь шуудангийн сүлжээ, түүний ашиглалт, үйлчилгээтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Шуудангийн тухай хууль тогтоомж

2.1. Шуудангийн тухай хууль тогтоомж нь Харилцаа холбооны тухай хууль¹, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр звасан бол тухайн олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "шуудан" гэж шуудангийн илгээмжийг хаягласан эзэнд нь хүргэх үйлдвэрлэл-технологийн иж бүрэн үйл ажиллагаа бүхий харилцаа холбооны төрлийг;

3.1.2. "шуудангийн сүлжээ" гэж шуудангийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын салбар, цэг болон тэдгээрийн хооронд шуудангийн илгээмж тээвэрлэх чиглэлийн нийлбэр цогцыг;

3.1.3. "шуудангийн илгээмж" гэж үйлчлүүлэгчээс шуудангийн сүлжээ ашиглан, хаягласан эзэнд нь хүргүүлэхээр захидал, боодол, илгээлтийн хэлбэрээр хүлээлгэн өгсөн биет зүйлийг;

¹ Харилцаа холбооны тухай хууль – Төрийн мэдээлэл эмхтгэлийн 2001 оны 43 дугаарт нийтлэгдсэн.



3.1.4. "захидал" гэж тодорхой этгээдэд хаягласан 500 граммаас илүүгүй жинтэй, дугтуйлсан болон дугтуйлаагүй шуудангийн илгээмжийг;

3.1.5. "боодол" гэж 1000 граммаас илүүгүй жинтэй, урт нь 245 мм, өндөр нь 35 мм, өргөн нь 150 мм-ээс илүүгүй хэмжээтэй хаягласан, захидлаас бусад шуудангийн илгээмжийг;

3.1.6. "илгээлт" гэж боодлоос овор хэмжээгээрээ том шуудангийн илгээмжийг;

3.1.7. "шуудангаар үйлчлэгч" гэж шуудангийн үйлчилгээ үзүүлэх эрх бүхий хуулийн этгээдийг;

3.1.8. "шуудангийн хайрцаг" гэж шуудангаар үйлчлэгчээс шуудангийн илгээмжийг хүргэхэд ашиглах зориулалтаар тодорхой цэгт байрлуулсан савыг;

3.1.9. "шуудангийн боцг" гэж шуудангийн илгээмж хийж тээвэрлэхэд зориулсан савыг;

3.1.10. "шуудангийн код" гэж шуудангаар үйлчлэгчийн салбар, цэгийн байршлыг тоогоор, эсхүл үсэг, тоо хосолсон хэлбэрээр илэрхийлсэн дугаарыг.

4 дүгээр зүйл. Монгол Улсын шуудан

4.1. Монгол Улсын шуудан нь нийт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шуудангийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй бөгөөд түүнийг шуудангаар үйлчлэгч этгээд /цаашид "үйлчлэгч" гэж/ эрхлэн явуулна.

4.2. Монгол Улсын шуудан нь дараахь төрөлтэй байна:

4.2.1. үйлчлэгчээс эрхлэн үзүүлж байгаа нийтийн шуудан;

4.2.2. төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын хэрэгцээнд ашиглагдах тусгай хэрэглээний шуудан;

4.2.3. аж ахуйн нэгж, байгууллагын дотоодод ашиглагдах дотоодын хэрэглээний шуудан.

4.3. Энэ хуулийн 4.2.2, 4.2.3-т заасан шуудангийн сүлжээ байгуулах, ашиглахтай холбогдсон харилцааг Харилцаа холбооны тухай хуулийн 20, 21 дүгээр зүйлд зааснаар зохицуулна.

5 дугаар зүйл. Шуудангийн үйл ажиллагаанд баримтлах зарчим

5.1. Шуудангийн үйл ажиллагаанд дараахь зарчмыг баримтална:

5.1.1. хууль дээдлэх;

5.1.2. шуудангийн үйлчилгээ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүртээмжтэй, шуурхай

байх;

5.1.3. үйлчлүүлэгчийн эрхийг хүндэтгэх;

5.1.4. шуудангийн илгээмжийг саадгүй, чөлөөтэй илгээх;

5.1.5. үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах, хамгаалах;

5.1.6. нийтийн шуудангийн үйлчилгээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тэгш эрхтэй оролцох;

5.1.7. шуудангийн сүлжээний ажиллагаа тогтвортой байх;

5.1.8. шуудангийн салбарт дагаж мөрдүүлэх стандарт, дүрэм нь харилцан уялдсан, нэгдмэл байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Шуудангийн талаархи төрийн зохицуулалт

6 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

6.1. Засгийн газар шуудангийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1. шуудангийн салбарт төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

6.1.2. шуудангийн үйлчилгээ үзүүлэхэд мөрдөх дүрмийг батлах;

6.1.3. шуудангийн илгээмжийг түр хадгалах, задлах, хураах болон устгахтай холбогдсон журмыг тогтоох;

6.1.4. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

7 дугаар зүйл. Шуудангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

7.1. Шуудангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1. шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигч үйлчлэгчийн үйлчилгээний давуу эрхийн бүсийг энэ хуулийн 9.1.1-д заасан саналыг үндэслэн тогтоох;

7.1.2. шуудангийн салбарыг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

7.1.3. үйлчлэгч болон шуудангийн илгээмж тээвэрлэгч этгээдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

7.1.4. шуудангийн нэгдсэн код батлах;

7.1.5. шуудангийн үнэт цаасыг үйлдвэрлэх бодлого боловсруулах, улсын фонд байгуулах, хяналт тавих;



7.1.6. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

8 дугаар зүйл. Бүх шатны Засаг даргын эрх хэмжээ

8.1. Шуудангийн талаар бүх шатны Засаг дарга дараахь эрх хэмжээтэй байна:

8.1.1. цаг үеийн болон байнгын саад бэрхшээл бүхий газарт байрладаг үйлчлүүлэгчид шуудангийн илгээмж хүргэхэд үйлчлэгчид дэмжлэг үзүүлэх;

8.1.2. хууль тогтоомжид заасан бусад эрх хэмжээ.

9 дүгээр зүйл. Харилцаа холбооны зохицуулах хорооны эрх хэмжээ

9.1. Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Зохицуулах хороо дараахь эрх хэмжээтэй байна:

9.1.1. шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигч үйлчлэгчийн үйлчилгээний давуу эрхийн бүс тогтоох санал боловсруулах;

9.1.2. энэ хуулийн 7.1.1-д заасан давуу эрхийн бусад шуудангийн үйлчилгээ үзүүлэгч бусад үйлчлэгчээс Харилцаа холбооны тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан шуудангийн бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг тогтоож, мөрдүүлэх;

9.1.3. шуудангийн нэгдсэн кодыг боловсруулах;

9.1.4. хууль тогтоомжид заасан бусад эрх хэмжээ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Нийтийн шуудангийн үйлчилгээ

10 дугаар зүйл. Шуудангийн үйлчилгээ

10.1. Шуудангийн үйлчилгээ нь шуудангийн илгээмжийг Монгол Улсын нутаг дэвсгэр дэх үйлчлүүлэгчид хүргэх дотоодын, гадаад улс орнууд дахь үйлчлүүлэгчид хүргэх улс хоорондын гэсэн зориулалттай байх бөгөөд түүнийг энэ хууль болон холбогдох бусад хууль, дүрэм, гэрээнд заасны дагуу үзүүлнэ.

10.2. Дараахь эрх бүхий этгээдийн баталсан хуваарь, чиглэлийн дагуу шуудангийн илгээмж хүргэх үйл ажиллагааг зохион байгуулж явуулна.

10.2.1. аймаг, нийслэл, хот хооронд шуудангийн илгээмж хүргэх хуваарь, чиглэлийг Зохицуулах хороо;

10.2.2. аймаг, нийслэл, сум, дүүрэг,

баг болон хот, тосгоны доторх шуудангийн илгээмж хүргэх хуваарь, чиглэлийг тухайн үйлчлэгч.

10.3. Улс хоорондын шуудангийн илгээмж хүргэх үйл ажиллагааг хоёр талын шуудангийн эрх бүхий байгууллаагын хооронд байгуулсан Монгол Улсын олон улсын болон үйлчлэгч хоорондын гэрээгээр зохицуулна.

11 дүгээр зүйл. Шуудангийн сүлжээ

11.1. Шуудангийн илгээмжийг хүлээн авах, ялган боловсруулах, дамжуулах, солилцох замаар хаягласан эзэнд нь хүргэх үйл ажиллагаа шуудангийн сүлжээгээр дамжин явагдана.

11.2. Энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан үйлчилгээнд ашиглагдах шуудангийн үндсэн сүлжээ нь төрийн мэдэлд байна.

11.3. Үйлчлэгч нь өөрийн шуудангийн сүлжээ байгуулан үйлчилгээгээ үзүүлж болно.

12 дугаар зүйл. Шуудангийн бүх нийтийн үйлчилгээ

12.1. Шуудангийн бүх нийтийн үйлчилгээнд үйлчлэгч нь байршил, хүргэх боломжоос үл хамааран Монгол Улсын нутаг дэвсгэр дэх нийт иргэн, аж ахуй нэгж, байгууллагад шуудангийн илгээмжийг энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан хугацаанд хүргэх үйлчилгээ хамаарна.

13 дугаар зүйл. Электрон шуудангийн үйлчилгээ

13.1. Үйлчлэгч нь электрон шуудангийн үйлчилгээ эрхэлж болно.

13.2. Электрон шуудангийн үйлчилгээнд шуудангийн сүлжээгээр дамжуулан факс, нийтийн электрон шуудан, электрон худалдаа, электрон баримт бичиг хүргэх зэрэг үйлчилгээ хамаарна.

14 дүгээр зүйл. Санхүүгийн үйлчилгээ

14.1. Үйлчлэгч нь өөрийн сүлжээг ашиглан захиалгат илгээмжийн худалдаа эрхэлнэ.

14.2. Энэ хуулийн 14.1-д зааснаас гадна өөрийн сүлжээг ашиглан хадгаламж, даатгал, тэтгэвэр, тэтгэмж, цалин хөлс олгох, мөнгөн гуйвуулга хийх зэрэг санхүүгийн бусад үйлчилгээг хууль тогтоомжид нийцүүлэн эрхэлж болно.

15 дугаар зүйл. Шуудангийн хэрэгсэл

15.1. Шуудангийн хэрэгсэл нь шуудангийн илгээмж хүлээн авах, ялган боловсруулах, тээвэрлэх, хүргэхэд зориулсан тоног төхөөрөмж, шуудангийн боцг, шуудангийн хайрцаг болон бусад хэрэгслээс бүрдэнэ.

15.2. Шуудангийн хэрэгсэл нь төрийн болон орон нутгийн, иргэн, хуулийн этгээдийн өмчлөлд



байж болно.

15.3. Шуудангийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор үйлчлэгч нь гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгийг ашиглаж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Үйлчлэгч, үйлчлүүлэгчийн эрх, үүрэг

16 дугаар зүйл. Үйлчлэгчийн эрх, үүрэг

16.1. Үйлчлэгч нь дараахь эрхтэй:

16.1.1. улс хоорондын шуудангийн үйлчилгээнд оролцох, гадаадын ижил төрлийн хуулийн этгээдтэй хамтран ажиллах;

16.1.2. үйлчилгээндээ захидлын дугтуй, ил захидал зэрэг өөрийн бүтээгдэхүүнийг хэрэглэх;

16.1.3. шуудангийн сүлжээ байгуулах, өргөтгөх, татан буулгах;

16.1.4. шаардлагатай гэж үзвэл шуудангийн зарим үйлчилгээг гэрээний үндсэн дээр бусад этгээдээр гүйцэтгүүлэх асуудлыг шийдвэрлэж, биелэлтэд нь хяналт тавих;

16.1.5. шуудангийн илгээмжид зохих журмын дагуу хяналт тавьж, битүүмжлэхийг үйлчлүүлэгчээс шаардах, илгээхийг хориглосон зүйлийг хүлээж авахаас татгалзах;

16.1.6. өөрийн байгууллагын таних тэмдэг, тусгай хувцас хэрэглэх;

16.1.7. хууль, гэрээнд заасан бусад эрх.

16.2. Шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигч үйлчлэгч нь энэ хуулийн 16.1-д зааснаас гадна дараахь эрхтэй:

16.2.1. энэ хуулийн 7.1.5-д заасан бодлогын хүрээнд шуудангийн марк гаргах асуудлыг эрхлэн зохион байгуулах;

16.2.2. шуудангийн үндсэн сүлжээ, түүний хэрэгсэл, бусад эд хөрөнгийг эзэмших, ашиглах, зохих журмын дагуу түрээслүүлэх.

16.3. Үйлчлэгч нь дараахь үүрэгтэй:

16.3.1. нийтэд хүртээмжтэй, үр ашигтай шуудангийн үйлчилгээ үзүүлэх;

16.3.2. шуудангийн үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах хэрэгсэлтэй байх;

16.3.3. шуудангийн үйлчилгээ үзүүлэхээр тогтоосон хугацаа, журмын тухай мэдээллийг үйлчлүүлэгчид гаргаж өгөх буюу мэдээлэх;

16.3.4. шуудангийн сүлжээ байгуулах, өргөтгөх, татан буулгах тухай Зохицуулах хороо болон хэрэглэгчид урьдчилан мэдэгдэх;

16.3.5. хууль, гэрээгээр хүлээсэн бусад үүрэг.

16.4. Шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигч үйлчлэгч нь энэ хуулийн 16.3-д зааснаас гадна дараахь үүрэгтэй:

16.4.1. үйлчилгээндээ орчин үеийн шуудангийн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх;

16.4.2. энэ хуулийн 12.1-д заасан бүх нийтийн үйлчилгээг эрхлэн үзүүлэх;

16.4.3. хуульд зааснаас бусад нөхцөлд шуудангийн үйлчилгээг үл зогсоох.

16.5. Ажил үүргээ гүйцэтгэж яваа энэ хуулийн 16.1, 16.2-т заасан үйлчлэгч байгууллагын ажилтан нь үйлчлүүлэгчийн нутаг дэвсгэрт болон бүх төрлийн тээврийн буудал, зогсоолд аливаа төлбөр, хураамжгүйгээр саадгүй нэвтрэх эрхтэй.

17 дугаар зүйл. Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг

17.1. Үйлчлүүлэгч дараахь эрхтэй:

17.1.1. үйлчлэгчээс стандартад тохирсон үйлчилгээ шаардах, мэдээлэл гаргуулж авах;

17.1.2. шуудангийн илгээмжийг үрэгдүүлсэн, гэмтээсэн тохиолдолд Иргэний хуульд заасны дагуу хохирлыг нөхөн төлүүлэх;

17.1.3. хууль, гэрээнд заасан бусад эрх.

17.2. Үйлчлүүлэгч дараахь үүрэгтэй:

17.2.1. илгээж байгаа зүйлийнхээ талаар үнэн зөв мэдээлэл өгөх;

17.2.2. шуудангийн үйлчилгээний хурвамжийг зохих журмын дагуу төлөх;

17.2.3. хууль, гэрээнд заасан бусад үүрэг.

ТАВДУГААР БҮЛЭГ

Шуудангийн үйлчилгээний тариф

18 дугаар зүйл. Тарифын хэмжээ

18.1. Үйлчлэгч нь дотоодын болон улс хоорондын шуудангийн үйлчилгээний тарифын талаархи саналаа үндэслэл, тооцооны хамт Зохицуулах хороонд хүргэнэ.

18.2. Зохицуулах хороо үйлчилгээний тариф тогтоох саналыг хянан үзэж, холбогдох саналаа 14 хоногийн дотор тухайн үйлчлэгчид хүргүүлнэ.

18.3. Үйлчлэгч нь Зохицуулах хорооны саналыг харгалзан үйлчилгээний тариф тогтоох



тухай шийдвэр гаргана.

18.4. Энэ хуулийн 18.3-т заасан шийдвэр гарснаас хойш энэ тухай 15 хоногийн дотор нийтэд мэдээлнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Шуудангийн илгээмжийн төрөл, зэрэглэл, хүргэх хугацаа

19 дүгээр зүйл. Шуудангийн илгээмжийн төрөл

19.1. Шуудангийн илгээмж нь дараахь онцлог бүхий энгийн, баталгаат, үнэ зарласан гэсэн төрөлтэй байна:

19.1.1. энгийн илгээмжид үйлчлүүлэгч өөрөө тарифын дагуу марк наасан энгийн захидал, баталгаат болон үнэ зарласнаас бусад боодол, илгээлт;

19.1.2. баталгаат илгээмжид үйлчлэгчээр батлуулан түүнийхээ төлөө нэмэлт хураамж төлж, хаягласан эзэнд нь гардуулах нөхцөлөөр илгээж буй захидал, боодол, илгээлт;

19.1.3. үнэ зарласан илгээмжид үйлчлүүлэгч илгээмжээ үнэлэн, нэмэгдэл төлбөр хийж илгээж байгаа захидал, боодол, илгээлт.

20 дугаар зүйл. Шуудангийн илгээмжийн зэрэглэл, хүргэх хугацаа

20.1. Шуудангийн илгээмжийг хүргэх хугацаагаар нь ердийн, шуурхай, буухиа гэж зэрэглэнэ.

20.2. Ердийн зэрэглэлийн илгээмжийг хотын дотор 2 хоног, аймаг, хотуудын хооронд 5 хоног, бусад газарт 12 хоногийн дотор хүргэсэн байна.

20.3. Шуурхай зэрэглэлийн илгээмжийг хотын дотор 1 хоног, аймаг, хотуудын хооронд 3 хоног, бусад газарт 10 хоногийн дотор хүргэсэн байна.

20.4. Буухиа зэрэглэлийн илгээмжийг хүргэх хугацаа нь гэрээнд зааснаар тодорхойлогдох бөгөөд энэ хуулийн 20.3-т заасан хугацаанаас богино байна.

21 дүгээр зүйл. Улс хоорондын шуудангийн илгээмж

21.1. Улс хоорондын шуудангаар шуудангийн илгээмжийг хүргэхтэй холбогдсон харилцааг Монгол Улсын олон улсын болон үйлчлэгч хоорондын гэрээ, холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Шуудангийн онцлог үйл ажиллагаа

22 дугаар зүйл. Шуудангийн үйл

ажиллагаанд хэрэглэх хэл

22.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр шуудангаар үйлчлэгч нь албан хэргээ монгол хэлээр хөтлөн явуулна.

22.2. Улс хоорондын шуудангийн илгээмжийн бүрдүүлэлтийг Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хэлээр хийнэ.

23 дугаар зүйл. Хаяг тодорхойгүй шуудангийн илгээмж

23.1. Хаяггүй буюу хаяг дутуу бичигдсэнээс хаягийг тодорхойлох, хаягт заасан этгээдийг тогтоож, зохих эзэнд нь хүргэж гардуулах боломжгүй шуудангийн илгээмжийг хаяг тодорхойгүй шуудангийн илгээмж гэнэ.

23.2. Шуудангаар үйлчлэгч байгууллагын ажилтан хаяг тодорхойгүй шуудангийн илгээмжийг энэ хуулийн 6.1.3-т зааснаар тодорхойлсон хадгалах хугацаа дуусмагц хүлээн авах буюу илгээсэн этгээдийн хаягийг тогтоох зорилгоор дараахь журмын дагуу задлана:

23.2.1. шуудангийн илгээмж задлахад үйлчлэгчийн хоёр, түүнээс дээш ажилтан оролцоно;

23.2.2. шуудангийн илгээмж задалсан үйл явцын талаар тэмдэглэл үйлдэнэ;

23.2.3. энэ хуулийн 24.1-д заасан шуудангаар илгээхийг хориглосон зүйл тухайн илгээмжид байвал түүнийг холбогдох байгууллагад шилжүүлнэ.

23.3. Шуудангийн илгээмжийг задалсны дараа хүлээн авах буюу илгээсэн этгээдийн хаяг тодорсон бол түүнд зохих шалтгаан, үндэслэлийг мэдэгдэнэ.

23.4. Энэ хуулийн 23.2 - 23.3-т заасан үйл ажиллагаа явуулсан боловч хаягт эзнийг тогтоох боломжгүй болсон тохиолдолд илгээмжийг холбогдох байгууллагад шилжүүлэх буюу энэ хуулийн 6.1.3-т заасан журмын дагуу устгана.

24 дүгээр зүйл. Шуудангийн үйл ажиллагаанд хориглох зүйл

24.1. Шуудангаар дараахь зүйл илгээхийг хориглоно:

24.1.1. галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх болон цацраг идэвхт бодис, түргэн шатамхай бодис, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэл;

24.1.2. хортон ургамал, амьтан;

24.1.3. хар тамхи, мансууруулах буюу хордуулах бодис;

24.1.4. хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын болон гадаад улсын мөнгөн тэмдэгт;



24.1.5. түргэн муудах хүнсний бүтээгдэхүүн;

24.1.6. садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад материал;

24.1.7. хууль тогтоомжоор хориглосон бусад зүйл.

24.2. Шуудангийн сүлжээгээр дамжиж байгаа бүх төрлийн илгээмжийг алдаж үрэгдүүлэх, гэмтээх, зохих зөвшөөрөлгүй задлах, мэдээллийн нууцыг задруулах болон шуудангийн маркыг хуурамчаар үйлдвэрлэх, хуулбарлахыг хориглоно.

25 дугаар зүйл. Шуудангийн марк

25.1. Шуудангийн илгээмж дээр "Монгол" гэсэн тодотгосон үгтэй шуудангийн марк наасан байна.

25.2. Шуудангийн марк нь Монгол Улсын шуудангийн үнэт цаас мөн бөгөөд төлбөрийн хэрэгсэл болно.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Хяналт, хариуцлага

26 дугаар зүйл. Шуудангийн сүлжээний ашиглалт үйлчилгээнд тавих хяналт

26.1. Шуудангийн сүлжээний ашиглалт, үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, техник технологийн горимын хэрэгжилтэд хууль

тогтоомжид заасны дагуу улсын байцаагч хяналт тавина.

27 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

27.1. Шуудангийн тухай хууль зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч буюу улсын байцаагч дараахь захиргааны шийтгэл ногдуулна:

27.1.1. энэ хуулийн 16.3.2-16.3.4, 16.4.2, 16.4.3, 20.2-20.4-т заасныг зөрчсөн үйлчлэгчийг 100000-250000 төгрөгөөр торгох;

27.1.2. энэ хуулийн 16.5-д заасныг зөрчсөн албан тушаалтныг 30000-60000, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000 төгрөгөөр торгох;

27.1.3. энэ хуулийн 18.1, 18.2, 18.4-т заасныг зөрчсөн үйлчлэгч болон эрх бүхий байгууллагыг 100000-200000 төгрөгөөр торгох;

27.1.4. энэ хуулийн 22.1, 23.2-23.4-т заасныг зөрчсөн үйлчлэгчийг 100000-150000 төгрөгөөр торгох;

27.1.5. энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасныг зөрчсөн иргэнийг 30000-50000, албан тушаалтныг 40000-60000, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-250000 төгрөгөөр торгох.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Харилцаа холбооны тухай хуулийн 3.1.11-ийн "цахилгаан холбооны" гэсний өмнө "шуудангийн болон" гэж; 11.1-ийн "зорилгоор" гэсний дараа "шуудангийн болон цахилгаан холбооны" гэж; мөн хэсгийн "санг" гэсний дараа "тус тус" гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Харилцаа холбооны тухай хуулийн 18 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"18 дугаар зүйл. Шуудангийн сүлжээ

18.1. Шуудангийн сүлжээ, түүний ашиглалт, үйлчилгээтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна."

3 дугаар зүйл. Харилцаа холбооны тухай хуулийн 3.1.5, 12.1.1-ийн "харилцаа холбооны нийтийн" гэснийг "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.8.7-д заасан" гэж; 11.1-ийн "цахилгаан" гэснийг "харилцаа", "хүргэхийн тулд" гэснийг "хүргэх," гэж; 3.1.11-3.1.15 дахь

заалтын дугаарыг "3.1.8-3.1.12" гэж; 6.1.8-6.1.10 дахь заалтын дугаарыг "6.1.7-6.1.9" гэж; 7.1.3-7.1.6 дахь заалтын дугаарыг "7.1.2-7.1.5" гэж; 32.1.7, 32.1.8 дахь заалтын дугаарыг "32.1.6, 32.1.7" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Харилцаа холбооны тухай хуулийн 26.1.3 дахь заалтын "шуудангийн илгээмжийг үрэгдүүлсэн, гэмтээсэн" гэснийг хассугай.

5 дугаар зүйл. Харилцаа холбооны тухай хуулийн 3.1.8-3.1.10, 6.1.7, 7.1.2, 12.1.3, 25.4, 27.1.2, 27.1.3, 32.1.6 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг Шуудангийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 15-ны өдөр

ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Улаанбаатар хот

1 дүгээр зүйл. Гаалийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн "онцлог бараа," гэсний дараа "түүнчлэн улс хоорондын шуудангийн илгээмж," гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Гаалийн тухай хуулийн 33 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"33 дугаар зүйл. Улс хоорондын шуудангийн илгээмж

Улс хоорондын шуудангийн илгээмжид гаалийн бүрдүүлэлт хийх журмыг гаалийн болон

шуудангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална."

3 дугаар зүйл. Гаалийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын "олон улсын шуудан илгээлт" гэснийг "улс хоорондын шуудангийн илгээмж" гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Шуудангийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 15-ны өдөр

АВТО ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Улаанбаатар хот

1 дүгээр зүйл. Авто тээврийн тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт:

"5.1.5. авто тээврийн хэрэгслийн төрөл, зориулалтыг нь харгалзан техникийн хяналтын үзэлгт орох хугацаа, оношлогооны төлбөрийн кишгийг ялгаавартай тогтоох."

2/ 17 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"17.4. Ашиглагдаж байгаад импортоор орж ирсэн тээврийн хэрэгслийг техникийн оношлогоонд оруулж, стандартын шаардлага хангуулсны дараа улсын бүртгэлд бүртгэж, дугаар олгоно."

3/ 19 дүгээр зүйл:

"19 дүгээр зүйл. Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах.

19'1. Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг энэ хуулийн 15.1-д заасан тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага эрхэлнэ.

19'2. Техникийн хяналтын үзлэг хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага дараахь нөхцөл, шаардлагыг хангана:

19'2.1. авто тээврийн хэрэгслийн техникийн ашиглалтын байдалд тавих шаардлагын дагуу техникийн хяналтын үзлэгийг / авто тээврийн хэрэгслийн ерөнхий байдал, иж бүрдэл, хөдөлгүүр, хүч дамжуулах анги, тоормосны систем, жолооны механизм, гэрэл дохио, явах анги, экологи болон

эргономикийн үзүүлэлт / бүрэн хийх;

19'2.2. техникийн хяналтын үзлэгийн талаархи дүрэм, журам, стандартыг мөрдөх;

19'2.3. үйлдвэрлэлийн байр, талбай, оношлогооны тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн стандартын үзүүлэлт, шаардлагыг хангаж, хэмжил зүйн мэргэжлийн байгууллагаар жил бүр шалгуулж, баталгаажуулах;

19'2.4. гүйцэтгэсэн ажил үйлчилгээний хэмжээ, үйл ажиллагааны мэдээ, тайланг тогтоосон үзүүлэлт, загвараар эрх бүхий байгууллагад тогтмол хугацаанд гаргаж өгөх.

19'3. Авто тээврийн хэрэгсэл өмчлөгч, эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн дараахь үүрэг хүлээнэ:

19'3.1. техникийн хяналтын үзлэг хийсэн гэрчилгээнд заасан хугацаанд авто тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулах;

19'3.2. авто тээврийн хэрэгсэл бүрийн техникийн бичиг баримтын бүрдлийг хангах."

2 дугаар зүйл. Авто тээврийн тухай хуулийн 23.1.1-ийн "17.2" гэсний дараа "19'2." гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Авто тээврийн тухай хуулийн 17.1-ийн "жил бүр" гэснийг "жилийн турш" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

СТАНДАРТЧИЛАЛ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь стандартчилал, тохирлын үнэлгээний эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль тогтоомж

2.1. Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль тогтоомжид зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "стандартчилал" гэж бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ /цаашид "бүтээгдэхүүн" гэх/-ний харилцан орлолт, аюулгүй байдал, мэдээлэл, техник, хэмжилт, сорилтын нийцтэй, нэгдмэл байдлыг хангах зорилгоор нийтлэг бөгөөд дахин давтан хэрэглэх журам тогтоох үйл ажиллагааг;

3.1.2. "стандарт" гэж бүтээгдэхүүний үзүүлэлт, шаардлагын хэм хэмжээг зохих журмын дагуу сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж, эрх бүхий байгууллагаас баталсан норматив-техникийн баримт бичгийг;

3.1.3. "техникийн зохицуулалт" гэж бүтээгдэхүүний үзүүлэлт, шаардлага, эсхүл түүнийг боловсруулах, үйлдвэрлэх аргыг заавал биелүүлэхээр эрх бүхий этгээдээс баталсан баримт бичгийг;

3.1.4. "тохирлын үнэлгээ" гэж бүтээгдэхүүн, эсхүл байгууллага нь стандарт, техникийн зохицуулалт, холбогдох норматив баримт бичигт заасан үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа

эсэхийг шууд буюу шууд бус байдлаар тодорхойлох үйл ажиллагааг;

3.1.5. "тохирлын үнэлгээний байгууллага" гэж тохирлын үнэлгээг хэрэгжүүлэх сорилтын лаборатори, баталгаажуулалт, техникийн хяналтын болон тэдгээрийг итгэмжлэх байгууллагаг;

3.1.6. "итгэмжлэл" гэж аливаа байгууллага, эсхүл хувь хүн нь тодорхой үйл ажиллагааг гүйцэтгэх чадавхтайг нь эрх бүхий байгууллагаас тогтоож албан ёсоор хүлээн зөвшөөрөх ажиллагааг;

3.1.7. "сорилт" гэж тухайн бүтээгдэхүүний тоон болон чанарын үзүүлэлтийг холбогдох журмын дагуу тодорхойлоход чиглэсэн техник ажиллагааг;

3.1.8. "тохирлын баталгаа" гэж бүтээгдэхүүн нь тогтоосон шаардлагад тохирч байгааг тодорхойлсон баримт бичиг олгохыг;

3.1.9. "баталгаажуулалт" гэж бүтээгдэхүүн, тогтолцоо нь тогтоосон шаардлагад нийцэж буйг хөндлөнгийн этгээд бичгээр нотлох ажиллагааг;

3.1.10. "нийлүүлэгчийн мэдэгдэл" гэж үйлдвэрлэгч, эсхүл нийлүүлэгчээс бүтээгдэхүүнээ тогтоосон шаардлагад нийцэж буй талаар бичгээр мэдэгдэл гаргах ажиллагааг;

3.1.11. "техникийн хяналт" гэж бүтээгдэхүүн, түүний зохион бүтээлт, үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ, ажлын байрны орчин нөхцөл нь ерөнхий болон тусгай шаардлагад тохирч байгаа эсэхийг мэргэшлийн үүднээс тодорхойлох ажиллагааг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Стандартчилал ба техникийн зохицуулалт

4 дүгээр зүйл. Стандартчиллын зорилго, зарчим

4.1. Стандартчиллын зорилго нь нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдлыг хамгаалах, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, бүх төрлийн нөөцийг зүй зохистой ашиглах, бүтээгдэхүүний харилцан орлолт, сорилт, хэмжилтийн нэгдмэл байдлыг хангахад оршино.

¹ Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийлэгдсэн



4.2. Стандартчилалд дараахь зарчмыг баримтална:

4.2.1. төр, үйлдвэрлэгч, хэрэглэгч тэгш эрхтэйгээр оролцох;

4.2.2. нийгмийн эрх ашигт нийцэх;

4.2.3. бие даасан, хараат бус байх;

4.2.4. стандарт нь шинжлэх ухаан,

технологийн сүүлийн үеийн түвшин, практикийн ололтод тулгуурласан, товч тодорхой агуулгатай байх;

4.2.5. олон улсын стандартыг үндэсний стандарт боловсруулахад үндэс суурь болгох;

4.2.6. стандарт нь үйлдвэрлэл, худалдаанд үндэслэлгүйгээр саад учруулахгүй байх;

4.2.7. стандарт нь бүтээгдэхүүний хэрэглээний болон ашиглалтын шинж чанарт үндэслэх;

4.2.8. хууль тогтоомжид харшилсан үзүүлэлт, шаардлагыг стандартад тусгахгүй байх.

5 дугаар зүйл. Стандартчиллын баримт бичиг

5.1. Стандартчиллын баримт бичигт дараахь баримт бичиг хамаарна:

5.1.1. Монгол Улсын /цаашид "үндэсний" гэх/ стандарт;

5.1.2. энэ хуулийн 9.1, 9.2-т заасны дагуу хэрэглэж байгаа стандарт, аргачлал, заавар болон олон улс, бүс нутгийн стандартчиллын байгууллагаас гаргасан арга зүйн удирдамж, зөвлөмж;

5.1.3. байгууллагын стандарт.

6 дугаар зүйл. Үндэсний стандарт

6.1. Үндэсний стандартын үзүүлэлт, шаардлага нь олон улс, бүс нутаг, гадаад улсын дэвшилтэй стандартын түвшинд хүрсэн байвал зохино.

6.2. Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдлыг хамгаалах объектод тогтоосон үндэсний стандартыг заавал мөрдөнө.

6.3. Энэ хуулийн 6.2-т зааснаас бусад үндэсний стандартыг сонгон хэрэглэнэ.

6.4. Үндэсний стандарт нь зохиогчийн эрхэд хамаарах бүтээл болохгүй.

6.5. Стандартчиллын техникийн хорооны хэлэлцэж дэмжсэн стандартын төслийг Стандартчиллын Үндэсний зөвлөл улсын хэмжээнд

хэрэглэхээр хүлээн зөвшөөрч үндэсний стандартаар батална.

6.6. Үндэсний стандарт нь товчилсон тэмдэглэгээ, улсын бүртгэлийн дугаартай байх бөгөөд түүнийг баталсан шийдвэрт өөрөөр заагаагүй бол улсын бүртгэлд бүртгэсэн тухай олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

6.7. Аж ахуйн нэгж, байгууллага нь гэрээ, холбогдох баримт бичигт үндэсний стандартыг хэрэглэх тухай заалтыг тусгаж болно.

7 дугаар зүйл. Техникийн хороо

7.1. Стандартчиллын Үндэсний зөвлөл нь үндэсний болон олон улсын стандартын төслийг боловсруулах, хэлэлцэх, дүгнэлт гаргах зорилго бүхий орон тооны бус салбарын стандартчиллын техникийн хороо /цаашид "техникийн хороо" гэх/-г төр, иргэн, аж ахуйн нэгж, шинжлэх ухааны болон бусад байгууллагын төлөөлөлтэйгээр байгуулж ажиллуулна.

7.2. Техникийн хороо нь дараахь эрх, үүрэгтэй байна:

7.2.1. стандартын төсөл, хөтөлбөрт холбогдох байгууллагын санал авах, сонирхогч талуудтай зөвшилцөх;

7.2.2. үндэсний болон олон улс, бүс нутгийн стандартын төсөлд санал өгөх, дүгнэлт гаргах;

7.2.3. техникийн дэд хороог байгуулах, стандартын төсөл боловсруулах;

7.2.4. стандартад үзлэг хийх, судалгаа шинжилгээ явуулах, холбогдох арга хэмжээний төсөл боловсруулах;

7.2.5. аль нэгэн байгууллагын ашиг сонирхлыг илэрхийлэхгүй байх;

7.2.6. батлуулахаар оруулсан стандартын боловсруулалтын түвшин, агуулга зохиц харилцааг байдлыг хариуцах.

8 дугаар зүйл. Байгууллагын стандарт

8.1. Аж ахуйн нэгж, байгууллага нь байгууллагын стандарт боловсруулан хэрэглэж болно.

8.2. Байгууллагын стандарт нь үндэсний стандарт, техникийн зохицуулалтын үзүүлэлт шаардлагад нийцсэн байна.

8.3. Байгууллагын стандартыг боловсруулах, батлах, аймаг, нийслэлийн стандартчиллын байгууллагад бүртгүүлэх ажлыг аж ахуйн нэгж, байгууллага хариуцна.



8.4. Байгууллагын стандарт нь товчилсон тэмдэглэгээ, нутаг дэвсгэрийн бүртгэлийн дугаартай байх бөгөөд түүнийг баталсан шийдвэрт өөрөөр заагаагүй бол бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

8.5. Энэ хуулийн 8.2-т заасан шаардлагыг хангаагүй байгууллагын стандартыг баримтлан үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахыг хориглоно.

9 дүгээр зүйл. Стандарт хэрэглэх

9.1. Аж ахуйн нэгж, байгууллага нь хууль тогтоомж, үйлдвэрлэгчийн болон хэрэглэгчийн эрх ашигт харшлахгүй, нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулахгүй олон улс, бус нутаг, гадаад улсын дэвшилтэй стандартыг Стандартчиллын төв байгууллагад бүртгүүлсний үндсэн дээр хэрэглэнэ.

9.2. Шинэ технологи, бүтээгдэхүүн эзэмшиж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад Монгол Улсад хэрэглэхээр зааснаас өөр стандарт, аргачлал, зааврыг нэг жил хүртэл хугацаагаар түр хэрэглэх зөвшөөрлийг стандартчиллын төв байгууллага олгоно.

9.3. Аж ахуйн нэгж, байгууллага үндэсний стандартыг хувиалан олшруулах, энэ хуулийн 6.5, 9.1, 9.2-т зааснаас өөр стандарт хэрэглэх, стандартын шаардлага хангаагүй бүтээгдэхүүнд стандартын товчилсон тэмдэглэгээ тавихыг хориглоно.

9.4. Энэ хуулийн 6.3-т заасан стандартыг халбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, техникийн зохицуулалтад заавал мөрдөхөөр иш татсан бол тэр нь заавал мөрдөх стандартын нэгэн адил үйлчилнэ.

10 дугаар зүйл. Техникийн зохицуулалт

10.1. Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, хуурамч бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор техникийн зохицуулалтыг хэрэглэнэ.

10.2. Техникийн зохицуулалтыг Засгийн газар батална.

10.3. Стандартчиллын төв байгууллага техникийн зохицуулалтын төсөлд шүүлт хийж, дүгнэлт гаргана.

10.4. Засгийн газар тухайн техникийн зохицуулалтыг мөрдүүлэх үндэслэл болж байсан нөхцөл, зорилго өөрчлөгдсөн тохиолдолд техникийн зохицуулалтыг хүчингүй болгох буюу түүнд өөрчлөлт оруулна.

10.5. Дэлхийн худалдааны байгууллагын

гишүүн орнуудаас санал болгож буй олон улсын худалдаанд хэрэглэх техникийн зохицуулалтыг улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөх асуудлыг худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.

10.6. Стандартчиллын төв байгууллага нь Монгол Улсаас олон улсын худалдаанд хэрэглэхээр санал болгосон техникийн зохицуулалтыг батлахаас гурваас доошгүй сарын өмнө Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнуудад энэ тухай мэдээлнэ.

11 дүгээр зүйл. Мэдээлэл

11.1. Стандартчиллын төв байгууллага нь мэдээлэл, лавлагааны төв ажиллуулна.

11.2. Мэдээлэл, лавлагааны төв нь бүтээгдэхүүнд хамаарах Олон улсын гэрээ хэлэлцээр, олон улс, бус нутаг, гадаад орны болон үндэсний стандарт, техникийн зохицуулалт, удирдамж, зөвлөмж, аргачлал, заавар, тохирлын үнэлгээний журам болон холбогдох норматив-техникийн бусад баримт бичгийн албан ёсны эх, эсхүл хуулбар хувимудаас бүрдсэн үндэсний мэдээллийн сантай байна.

11.3. Мэдээлэл, лавлагааны төв нь төрийн мэдээллийн нөөц бөгөөд энэ хуулийн 11.2-т заасан баримт бичгийг төвлөрүүлэн бүрдүүлэх, хүлээн авах, бүртгэх, хадгалах, хамгаалах, мэдээлэх, хэвлэх, борлуулах үйлчилгээ эрхэлнэ.

11.4. Мэдээлэл, лавлагааны төв нь үнэн зөв, бодит мэдээллээр нийтэд үйлчилнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Тохирлын үнэлгээ

12 дугаар зүйл. Тохирлын үнэлгээний зорилго, төрөл, зарчим

12.1. Тохирлын үнэлгээг бүтээгдэхүүнд хэрэглэгчийн итгэх итгэлийг нэмэгдүүлэх, зөв сонголт хийхэд туслал, хуурамч бүтээгдэхүүнээс хэрэглэгчийг хамгаалах, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор хэрэглэнэ.

12.2. Тохирлын үнэлгээ нь итгэмжлэл, сорилт, баталгаажуулалт, техникийн хяналт гэсэн төрөлтэй байна.

12.3 Тохирлын үнэлгээнд дараахь зарчмыг баримтална:

- 12.3.1. бие даасан, хараат бус байх;
- 12.3.2. бодитой, үнэнч, шударга байх;
- 12.3.3. хүсэлт гаргагч бүх талд адил тэгш нөхцөл олгох;
- 12.3.4. нээлттэй, хүртээмжтэй байх;
- 12.3.5. хүсэлт гаргагчийн нууцад хамаарах мэдээллийг хамгаалах.



12.4. Тохирлын үнэлгээг стандарт, техникийн зохицуулалт болон холбогдох норматив-техникийн баримт бичигт үндэслэн явуулна.

12.5. Тохирлын үнэлгээний байгууллага нь тохирлын үнэлгээг мэргэжлээрээ гурваас доошгүй жил ажилласан, дадлага туршлагатай, тухайн чиглэлээр мэргэшсэн шинжээчээр гүйцэтгүүлнэ.

12.6. Тохирлын үнэлгээний байгууллага нь үнэлгээний дүнг буруу гаргасан тохиолдолд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

13 дугаар зүйл. Итгэмжлэл

13.1. Итгэмжлэлд сорилтын лаборатори, баталгаажуулалт, техникийн хяналтын байгууллага хамрагдаж болно.

13.2. Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүний сорилтын лаборатори, баталгаажуулалт, техникийн хяналт явуулах байгууллага нь заавал итгэмжлэгдэнэ.

13.3. Итгэмжлэлийг улсын хэмжээнд Стандартчиллын төв байгууллага эрхлэн гүйцэтгэнэ.

13.4. Итгэмжлэлийн тогтолцоо нь итгэмжлэлийн байгууллага, итгэмжлэлийн техникийн хороод, маргаан шийдвэрлэх комиссын үйл ажиллагаанаас бүрдэнэ.

13.5. Итгэмжлэлд орон тооны бус шинжээчийг гэрээний үндсэн дээр ажиллуулж болно.

13.6. Итгэмжлэлийн байгууллага нь дараахь бүрэн эрхтэй:

13.6.1. итгэмжлэлийн техникийн хорооны дүгнэлтийг үндэслэн итгэмжлэлийн гэрчилгээ олгох;

13.6.2. итгэмжлэлийн техникийн хороод байгуулж, тэдгээрийн дүрмийг батлах, үйл ажиллагааг зохицуулах;

13.6.3. итгэмжлэгдсэн сорилтын лаборатори, баталгаажуулалт, техникийн хяналтын байгууллагын улсын бүртгэлийг хөтлөх;

13.6.4. итгэмжлэгдсэн сорилтын лаборатори, баталгаажуулалт, техникийн хяналтын байгууллагын үйл ажиллагаанд магадлан шалгалт хийх;

13.6.5. итгэмжлэгдсэн сорилтын лаборатори, баталгаажуулалт, техникийн хяналтын байгууллага нь зохих шаардлага, шалгуурыг хангахгүй байгаа нь тогтоогдвол итгэмжлэлээр тогтоосон хүрээг багасгах, итгэмжлэлийг түдгэлзүүлэх, цуцлах арга хэмжээ авах.

13.7. Итгэмжлэлийн шинжээч нь дараахь эрх, үүрэгтэй байна:

13.7.1. итгэмжлэлийн байгууллагын шийдвэрээр сорилтын лаборатори, баталгаажуулалт, техникийн хяналтын байгууллага нь тогтоосон шалгуур үзүүлэлтэд нийцэж байгаа эсэхийг газар дээр нь шалган үнэлэх;

13.7.2. итгэмжлэлийн үнэлгээний талаар эцсийн дүгнэлт гарахаас өмнө тодорхой асуудлаар хувийн үнэлгээ, байр сууриа илэрхийлэхгүй байх;

13.7.3. итгэмжлүүлэхээр хүсэлт гаргагч байгууллагатай хөдөлмөрийн болон бусад гэрээгээр хамтран ажилладаг бол итгэмжлэлд оролцохоос татгалзах.

13.8. Итгэмжлэлийн техникийн хороо нь төр, аж ахуйн нэгж, шинжлэх ухааны болон бусад байгууллагын төлөөлөл бүхий орон тооны бус байдлаар ажиллана.

13.9. Итгэмжлэлийн техникийн хороо нь дараахь эрх, үүрэгтэй байна:

13.9.1. итгэмжлэгдэх байгууллага нь итгэмжлэлийн шаардлага, шалгуурыг хангасан эсэх талаар дүгнэлт гаргах;

13.9.2. итгэмжлэл явуулахдаа олж мэдсэн технологийн болон худалдааны мэдээ, материалыг задалж, тараахгүй байх.

13.10. Итгэмжлэлд оролцогч талуудын хооронд гарсан аливаа гомдол, маргааныг Маргаан шийдвэрлэх комисс шийдвэрлэнэ.

13.11. Маргаан шийдвэрлэх комисс нь төрийн болон шинжлэх ухааны байгууллага, хэрэглэгч, Стандартчиллын төв байгууллагын төлөөлөл бүхий таван хүний бүрэлдэхүүнтэй байна.

13.12. Маргаан шийдвэрлэх комиссын бүрэлдэхүүн, дүрмийг стандартын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

13.13. Маргаан шийдвэрлэх комисс нь шийдвэр гаргахдаа хараат бус, бие даасан, сонирхлын зөрчилгүй байх зарчим баримтална.

13.14. Итгэмжлэгдсэн байгууллага нь дараахь эрх, үүрэгтэй байна:

13.14.1. тохирлын үнэлгээг итгэмжлэлээр тогтоосон хүрээнд явуулах;

13.14.2. итгэмжлэлээр тогтоосон хүрээнд итгэмжлэгдээгүй байгууллага хооронд үүссэн маргааныг шийдвэрлэх;

13.14.3. итгэмжлэлийн шалгуурыг байнга, тогтвортой хангаж, зохих дүрэм, журам,



зааврыг мөрдөх;

13.14.4. итгэмжлэлийн нэр хүндийг зүй бусаар ашиглахгүй байх;

13.14.5. үйл ажиллагааны зохион байгуулалт, харьяалал, чиглэл, техник хангамж өөрчлөгдсөн тохиолдолд энэ хуулийн 13.6-д заасан байгууллагад арван дөрөв хоногийн дотор мэдээлэх.

14 дүгээр зүйл. Сорилтын лаборатори

14.1. Дараахь шаардлага хангасан сорилтын лабораторид итгэмжлэл олгоно:

14.1.1. сорилтын үр дүнг үйлдвэрлэгч, борлууллагч, хяналтын байгууллагаас удирдлагын болон санхүүгийн хувьд хараат бус, бие даасан байдлаар гаргах нөхцөл бүрдүүлсэн байх;

14.1.2. сорилтын стандарт, эрх бүхий байгууллагаас баталсан аргачлалын дагуу явуулах, зориулалтын өндөр нарийвчлал бүхий баталгаатай багаж, тоног төхөөрөмжтэй байх;

14.1.3. сорилт явуулахад шаардагдах стандарт, аргачлал, стандартчилсан загвар, холбогдох бусад материалыг хүрэлцэхүйц хэмжээгээр бүрдүүлсэн байх;

14.1.4. сорилт явуулах нөхцөл, орчинг холбогдох стандартын дагуу хангасан байх;

14.1.5. сорилтын үр дүнгийн үнэн зөв, найдвартай байдлыг хангах чанарын гарын авлагатай байх.

14.2. Сорилтын лаборатори нь хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, шалгалт тохируулга, бүтээгдэхүүний сорилт, шинжилгээ, оношлогооны гэсэн төрөлтэй байна.

14.3. Сорилтын лаборатори нь сорилтын үр дүнг бие даасан, хараат бус байдлаар гаргана.

14.4. Сорилтын лаборатори нь үр чадварыг үнэлэх чиглэлээр сорилт явуулахаар итгэмжлэгдсэн байгууллагаар сорилт гүйцэтгэх үр чадвараа жилд нэгээс доошгүй удаа тогтоолгож байна.

15 дугаар зүйл. Тохирлын баталгаа

15.1. Тохирлын баталгаа нь баталгаажуулалт, нийлүүлэгчийн мэдэгдэл гэсэн хоёр хэлбэртэй байна.

15.2. Үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчээс бүтээгдэхүүндээ нийлүүлэгчийн мэдэгдэл гаргаж болно.

15.3. Нийлүүлэгчийн мэдэгдлийг баталгаажуулалтын байгууллагаас хүлээн

зөвшөөрч болно. Хүлээн зөвшөөрсөн нийлүүлэгчийн мэдэгдэл нь энэ хуулийн 16.4-т заасан тохирлын гэрчилгээний нэгэн адил хүчин төгөлдөр байна.

16 дугаар зүйл. Баталгаажуулалт

16.1. Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэл ахлалснаас хойш гурван сарын дотор тохирлын баталгаанд заавал хамруулна.

16.2. Энэ хуулийн 16.1-д заасан бүтээгдэхүүний жагсаалт, тэдгээрийг тохирлын баталгаатайгаар Монгол Улсын зах зээлд нийлүүлэх, хилээр нэвтрүүлэх журмыг Засгийн газар батална.

16.3. Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 16.1-д зааснаас бусад бүтээгдэхүүн, чанарын болон байгаль орчны зэрэг удирдлагын тогтолцоо, шинжээчээ баталгаажуулалтад сайн дурын үндсэн дээр хамруулж болно.

16.4. Баталгаажуулалтын байгууллага нь зохих журмын дагуу баталгаажуулалтад тэнцсэн гадаадын болон дотоодын аж ахуйн нэгж, байгууллагын бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ / цаашид "тохирлын гэрчилгээ" гэх / олгоно.

16.5. Баталгаажуулалтын байгууллага нь итгэмжлэгдсэн сорилтын лаборатори, техникийн хяналтын байгууллагатай гэрээ байгуулж тэдгээрийн сорилт, техникийн хяналтын үр дүнг ашиглаж болно.

16.6. Тохирлын гэрчилгээ, үндэсний тохирлын тэмдэг олгосон нь түүнийг эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага чанар муутай бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулснаас хэрэглэгчид хохирол учруулсан тохиолдолд түүнд зохих хариуцлага хүлээлгэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

16.7. Бүтээгдэхүүний сорилтын болон тохирлын баталгааны үр дүнг хэрэглэх, харилцан хүлээн зөвшөөрөх талаар Монгол Улсаас олон улс, бус нутгийн байгууллага, худалдааны түнш орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрээр тохирсон хүчин төгөлдөр тохирлын болон түүнтэй адилтгах тэмдэг, гэрчилгээг Стандартчиллын төв байгууллагаас зөвшөөрнө.

16.8. Энэ хуулийн 16.7-д заасны дагуу зөвшөөрөгдсөн болон үндэсний тохирлын тэмдэгтэй бараа бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, экспортлох, импортлоход хяналт, баталгаажуулалтад давтан хамруулахгүй.

16.9. Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын технологийн тогтвортой байдал, удирдлагын тогтолцоог нэвтрүүлсэн байдлыг харгалзан тохирлын гэрчилгээг гурваас доошгүй жилийн хугацаагаар олгоно.

16.10. Тохирлын гэрчилгээнд

батаргаажуулалтын байгууллагын болон баталгаажуулалтад тэнцсэн аж ахуйн нэгж, байгууллагын нэр, стандарт, техникийн зохицуулалтын дугаар, сорилтын үр дүн, бүтээгдэхүүний болон удирдлагын тогтолцооны гэрчилгээний дугаар, бүтээгдэхүүн нь нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд үзүүлэх нөлөөллийн талаар тусгана.

16.11. Тохирлын гэрчилгээ нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр үйлчилнэ.

16.12. Стандартчиллын төв байгууллага нь бүтээгдэхүүнд баталгаажуулалт хийж үндэсний тохирлын тэмдэг олгож, улсын бүртгэлд бүртгэнэ.

16.13. Энэ хуулийн 16.1-д заасан бүтээгдэхүүний баталгаажуулалтын байгууллага дараахь эрх, үүрэгтэй байна:

16.13.1. баталгаажуулалтын схемийн дагуу баталгаажуулалт хийж;

16.13.2. тохирлын гэрчилгээ олгох, нийлүүлэгчийн мэдэгдлийг бүртгэх, тэдгээрийг хүчингүй болгох;

16.13.3. баталгаажуулалтад хамрагдсан бүтээгдэхүүнд хяналт тавих;

16.13.4. энэ хуулийн 16.13.2-т заасан шийдвэрийн талаар хяналтын болон гаалийн байгууллагад мэдээлэх;

16.13.5. шаардлагатай гэж үзвэл бүтээгдэхүүн нь нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд сөрөг нөлөөгүй болохыг нотолсон дүгнэлтийг холбогдох байгууллагуудаас гаргуулах;

16.13.6. холбогдох мэргэжлийн хүмүүсийг баталгаажуулалтад татан оролцуулах.

16.14. Энэ хуулийн 16.1-д заасан бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхэд дараахь нийтлэг шаардлага тавина:

16.14.1. бүтээгдэхүүнийг тохирлын баталгаатайгаар нийлүүлэх талаар худалдааны гэрээ, хэлэлцээрт тусгасан байх;

16.14.2. экспорт, импортын бүтээгдэхүүнийг тохирлын гэрчилгээ болон түүнтэй адилтгах баримт бичиггүйгээр улсын хилээр нэвтрүүлэхгүй байх.

16.15. Энэ хуулийн 16.1-д зааснаас бусад бараа, бүтээгдэхүүнийг заавал тохирлын баталгаатайгаар харилцан нийлүүлэхээр худалдааны гэрээ, хэлэлцээрт тусгасан бол тэдгээрийг улсын хилээр нэвтрүүлэхэд энэ хуулийн 16.14.2-ыг баримтална.

16.16. Шинжээч нь энэ хуулийн 16.1-д заасан бүтээгдэхүүнд баталгаажуулалт явуулахдаа аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэн

орох, мэдээ баримтыг авч танилцах, шаардлагатай багаж, тоног төхөөрөмж хэрэглэх, бүтээгдэхүүнээс дээж авах, илэрсэн зөрчлийн талаар холбогдох байгууллагад мэдээлэх эрх, үүрэгтэй байна.

17 дугаар зүйл. Техникийн хяналт

17.1. Техникийн хяналт нь үйлдвэрлэгчийн ба хөндлөнгийн гэсэн хэлбэртэй байна.

17.2. Техникийн хяналтын байгууллага нь бүтээгдэхүүн, түүний зохион бүтээлт, үйлдвэрлэл, ажил үйлчилгээ, ажлын байрны орчин нөхцөл, хэвийн ажиллагаа, аюулгүй байдлын үзүүлэлт нь стандартаар тогтоосон шаардлагад нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргана.

17.3. Техникийн хяналтын байгууллага нь энэ хуулийн 12.5-д заасан шинжээчийн ажиллах нөхцөл, шаардлага, түүнчлэн техникийн хяналт явуулах тоног төхөөрөмжийг бүрэн хангасан байна.

17.4. Техникийн хяналтыг тухайн чиглэлээр итгэмжлэгдсэн байгууллага болон мэргэшсэн, эрх бүхий шинжээч гүйцэтгэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Стандартчилал, тохирлын үнэлгээг хэрэгжүүлэх байгууллага, тэдгээрийн бүрэн эрх

18 дугаар зүйл. Стандартчиллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

18.1. Стандартчиллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхтэй:

18.1.1. эрхэлсэн салбар, чиглэлийнхээ техникийн бодлогыг стандартчилал, техникийн зохицуулалтад тусгаж хэрэгжүүлэх;

18.1.2. холбогдох чиглэл, салбарын техникийн зохицуулалт боловсруулах, стандартчиллын ажилд төлөөллөө оролцуулах;

18.1.3. салбарын чиглэлээр сорилтын лабораториудыг бэхжүүлэх, тэдгээрийн техникийн түвшинг дээшлүүлэх арга хэмжээ авах;

18.1.4. Олон улсын стандартчиллын болон бусад байгууллагуудаас баталсан тухайн чиглэлийн стандартыг энэ хуулийн 11.1-д заасан байгууллагад хүргүүлэх.

19 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

19.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга дараахь бүрэн эрхтэй:

19.1.1. нутаг дэвсгэртээ



Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

19.1.2. тухайн нутаг дэвсгэрт сорилтын лаборатори, баталгаажуулалт, техникийн хяналтын байгууллагыг бэхжүүлэх, техникийн түвшинг дээшлүүлэх талаар дэмжлэг, туслалцаа үзүүлэх, тэдгээрийг итгэмжлүүлэх арга хэмжээ авах.

20 дугаар зүйл. Стандартчиллын Үндэсний зөвлөл

20.1. Стандартчиллын Үндэсний зөвлөл /цаашид "Үндэсний зөвлөл" гэх/ нь төрийн болон төрийн бус, шинжлэх ухааны холбогдох байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөллөөс бүрдэнэ.

20.2. Үндэсний зөвлөл дараахь бүрэн эрхтэй:

20.2.1. Үндэсний стандарт, стандартчиллын хөтөлбөрийг батлах, хүчингүй болгох;

20.2.2. хууль тогтоомжид нийцүүлэн стандартчилал, тохирлын үнэлгээний ажлын хэтийн бодлого, чиглэлийг тодорхойлох;

20.2.3. стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээтэй холбогдсон дүрэм, журам, зааврыг батлах;

20.2.4. стандартчиллын техникийн хороодыг байгуулах, тэдгээрийн дүрмийг батлах.

20.3. Засгийн газар Үндэсний зөвлөлийн гишүүдийг томилж, чөлөөлнө.

20.4. Үндэсний зөвлөлийг Стандартчиллын төв байгууллагын дарга тэргүүлнэ.

21 дүгээр зүйл. Стандартчиллын байгууллагын тогтолцоо

21.1. Стандартчиллын байгууллагын тогтолцоо нь төв болон орон нутгийн байгууллагаас бүрдэнэ.

21.2. Стандартчиллын төв байгууллагын зохион байгуулалтын бүтцийг стандартын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

22 дугаар зүйл. Стандартчиллын төв байгууллага

22.1. Стандартчиллын төв байгууллага нь улсын хэмжээнд стандартчилал, тохирлын үнэлгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мөн.

22.2. Стандартчиллын төв байгууллага нь дараахь бүрэн эрхтэй:

22.2.1. стандартчилал, тохирлын үнэлгээний талаарх төрийн бодлого, хөтөлбөр, төсөл боловсруулан эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх, гүйцэтгэлийг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

22.2.2. стандартчилал, тохирлын үнэлгээний асуудлаар шинжлэх ухаан технологийн судалгаа, шинжилгээ хийх;

22.2.3. эрхэлсэн асуудлаар дүрэм, журам, заавар боловсруулах, холбогдох байгууллагуудад мэдээлэл, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэргэшлийн удирдлагаар хангах;

22.2.4. стандартчиллын техникийн хороодын үйл ажиллагааг зохицуулах;

22.2.5. эрхэлсэн асуудлаараа аж ахуйн нэгж, байгууллагын захиалга, тэдгээртэй байгуулсан гэрээний дагуу төлбөртэй ажил, үйлчилгээ, сургалт явуулах;

22.2.6. эрхэлсэн асуудлаараа олон улсын байгууллагад гишүүнээр элсэх, олон улс, бүс нутаг, гадаад улсын холбогдох байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх, тохирлын үнэлгээний үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх;

22.2.7. гаальд баталгаажуулалтын алба байгуулж ажиллуулах;

22.2.8. сорилтын лаборатори, итгэмжлэл, баталгаажуулалт, техникийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг олон улсын болон бүс нутгийн байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэх ажлыг зохион байгуулах.

22.3. Стандартчилал, тохирлын үнэлгээний асуудлаар сургалт явуулах, мэдээлэл арга зүйн туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх чиг үүргийг Засгийн газрын шийдвэрээр төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

22.4. Аймаг, нийслэлийн стандартчиллын байгууллагын удирдлагыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн Стандартчиллын төв байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

22.5. Стандартчиллын төв байгууллагын дүрмийг Засгийн газар батлана.

23 дугаар зүйл. Орон нутгийн стандартчиллын байгууллагын бүрэн эрх

23.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга аймаг, нийслэлийн стандартчиллын байгууллагыг байгуулж ажиллуулна.

23.2. Аймаг, нийслэлийн стандартчиллын байгууллага нь дараахь бүрэн эрхтэй:

23.2.1. нутаг дэвсгэртээ энэ хуулийн 22.2.3, 22.2.5-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

23.2.2. стандарт боловсруулах талаар арга зүйн зөвлөлгөө өгөх ажлыг зохицуулах, байгууллагын стандартын бүртгэл хөтлөх;

23.2.3. мэдээлэл, лавлагааны төвийн салбарыг орон нутагт байгуулан ажиллуулах;

23.2.4. сорилт, баталгаажуулалтыг энэ хуульд заасны дагуу явуулах.

24 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эрх, үүрэг

24.1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн дараахь эрх, үүрэгтэй:

24.1.1. стандарт, техникийн зохицуулалтад заасан үзүүлэлт, шаардлагыг биелүүлэх;

24.1.2. өөрийн бүтээгдэхүүний стандарт боловсруулах ажлыг санхүүжүүлэх;

24.1.3. бүтээгдэхүүнийхээ чанар, аюулгүй байдлыг хангах;

24.1.4. энэ хуулийн 16.1-д заасан бүтээгдэхүүнээ баталгаажуулалтад зохих хугацаанд хамруулах, түүнтэй холбогдсон зардлыг хариуцах;

24.1.5. өөрийн бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх чиглэлээр чанарын болон байгаль орчны зэрэг удирдлагын нийтлэг, дэвшилттэй аргыг нэвтрүүлэх;

24.1.6. шаардлагатай тохиолдолд стандартчиллын техникийн хорооны ажилд төлөөллөө оролцуулах;

24.1.7. шинэ бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, үйлдвэрлэлийн технологийг боловсронгуй болгохтой холбогдсон стандарт, арга зүйг ажиллагсаддаа эзэмшүүлэх;

24.1.8. мэргэжлийн хяналтын улсын байцаагчид ажлаа саадгүй явуулахад нь шаардагдах нөхцөл, мэдээлэл, техник хэрэгслээр хангах.

25 дугаар зүйл. Стандарт, тохирлын үнэлгээний талаарх мэргэжлийн хяналт

25.1. Стандарт, тохирлын үнэлгээний талаарх мэргэжлийн хяналтыг улсын хэмжээнд мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх төв болон орон нутгийн байгууллага хэрэгжүүлнэ.

25.2. Мэргэжлийн хяналтад дараахь зүйлийг

хамруулна:

25.2.1. стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль тогтоомж, заавал мөрдөх үндэсний стандарт, техникийн зохицуулалтын мөрдөлт;

25.2.2. энэ хуулийн 16.1-д заасан бүтээгдэхүүнийг баталгаажуулалтад хамруулсан эсэх;

25.2.3. бүтээгдэхүүний зориулалт, чанарын төлөв байдал нь сав, баглаа боодол, хаяг, шосго, бусад мэдээлэлтэй нийцэж байгаа эсэх.

25.3. Энэ хуулийн 25.2-т заасан хяналтыг хэрэгжүүлэх улсын байцаагч нь стандартчилал, тохирлын үнэлгээний чиглэлээр сургалтад хамрагдсан байна.

25.4. Стандарт, тохирлын үнэлгээний талаар мэргэжлийн хяналт гүйцэтгэх стандартын хяналтын улсын байцаагчийн эрхийг Төрийн хяналт, шалгалтын тухай² хуулийн 10.4-д заасны дагуу олгоно.

25.5. Стандартын хяналтын улсын байцаагч нь Төрийн хяналт, шалгалтын тухай хуульд зааснаас гадна дараахь бүрэн эрхтэй:

25.5.1. заавал мөрдөх стандарт, техникийн зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд бүтээгдэхүүнийг борлуулахыг хориглох, тохироогүй нөхцөлд үйлдвэрлэл, үйлчилгээ явуулсан тохиолдолд үйл ажиллагааг түр буюу бүрмөсөн зогсоох, шаардлагатай гэж үзвэл үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг зохих журмын дагуу устгуулах;

25.5.2. хяналтыг хэрэгжүүлэхдээ бусдын нөлөөнд үл автан албан үүргээ шударгаар биелүүлж, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, технологийн холбоотой нууцыг чандлан хадгалах;

25.5.3. зөрчлийг өөр байдлаар арилгах боломжгүй тохиолдолд үйлдвэрлэлийн ажиллагаа /арга/, ашиглалтыг хэсэгчлэн ба бүрэн зогсоох талаар шийдвэр гаргах;

25.5.4. хяналтын үр дүнд тавьсан акт, торгууль, гаргасан шийдвэр, албан шаардлагынхаа үнэн зөвийг бүрэн хариуцах.

25.6. Стандартын хяналтын улсын байцаагчид дараахь үйлдлийг хориглоно:

25.6.1. аливаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ашиг сонирхлыг төлөөлөх, тэдгээрт ашигтай давуу тал бий болгосон шийдвэр гаргах;

25.6.2. шалгалтын дүн болон хувь

² Төрийн хяналт шалгалтын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмтгэлийн 2003 оны 2 дугаарт нийтлэгдсэн



хүн, аж ахуйн нэгж, байгууллагын нууцыг задруулах;

бууруу гаргасан бол 150000-200000 төгрөгөөр торгох;

25.6.3. итгэмжлэл, баталгаажуулалт, техникийн хяналтын шинжээчийн үүргийг давхардуулан гүйцэтгэхгүй байх.

27.1.3. энэ хуулийн 6.2, 8.5-йг зөрчсөн, 16.1-д заасан бүтээгдэхүүнийг баталгаажуулалтад хугацаанд нь хамруулаагүй иргэнийг 10000-20000, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000 төгрөгөөр торгох;

25.7. Мэргэжлийн хяналтын байгууллага нь нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй бүтээгдэхүүний талаар иргэний мэдээллийн дагуу шалгалт явуулж болох бөгөөд үнэн зөв, онцгой чухал мэдээлэл өгсөн иргэнийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу урамшуулах буюу мэдээллийг худалдан авч болно.

27.1.4. сорилт, баталгаажуулалт, техникийн хяналтыг энэ хуулийн 13.2-т заасныг зөрчиж явуулсан бол аж ахуйн нэгж байгууллагыг 100000-150000 төгрөгөөр торгох;

27.1.5. итгэмжлэгдсэн байгууллага нь энэ хуулийн 13.14.1-д заасан эрхээ хэтрүүлж үйл ажиллагаа явуулсан бол тухайн үйл ажиллагаанаас олсон орлогыг хурааж, аж ахуйн нэгж байгууллагыг 100000-150000 төгрөгөөр торгох;

ТАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

26 дугаар зүйл. Стандартчилал, тохирлын үнэлгээний санхүүжилт

27.1.6. Энэ хуулийн 9.3-д заасныг зөрчсөн, эсхүл бүтээгдэхүүний чанарын ангилал, зэргийг зориуд өгсгөсөн буюу улсын стандартын тэмдэглэгээ, тохирлын үнэлгээний үр дүнг хууль бусаар ашигласан бол хууль бусаар олсон орлогыг хурааж зөрчил гаргасан иргэнийг 20000-40000, албан тушаалтныг 30000-50000, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-200000 төгрөгөөр торгох.

26.1. Стандартчиллын төв болон орон нутгийн байгууллагаас энэ хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон зардал, Үндэсний зөвлөл, стандартчиллын ба итгэмжлэлийн техникийн хороо, итгэмжлэлийн маргаан шийдвэрлэх комиссын үйл ажиллагаатай холбогдсон зардал болон Олон улсын байгууллагын гишүүний татаварыг улсын төсвөөс, энэ хуулийн 22.2.2-т заасан үйл ажиллагааны зардлыг шинжлэх ухаан, технологийн сангаас, бусад зардлыг тухайн байгууллагын төрийн нэрийн өмнөөс гүйцэтгэсэн төлбөрт ажил үйлчилгээний орлогоос тус тус санхүүжүүлнэ.

27.2. Стандартын хяналтын улсын байцаагч эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашигласан, төрийн хяналтыг хэрэгжүүлэхэд зориулан олгосон эд хөрөнгийг өөр зориулалтаар ашигласан бол түүнд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

26.2. Энэ хуулийн 13.2, 16.1, 22.2.5-д заасан ажил, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээг стандартын болон төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтооно.

27.3. Стандартын хяналтын улсын байцаагчид албан үүргээ гүйцэтгэхэд нь саад учруулсан, эсэргүүцэл үзүүлсэн, заналхийлсан, үйл ажиллагаатай нь холбогдуулан мөрдөн хавчсан, эрүүд мэндэд нь хохирол учруулсан гэм буруутай этгээдэд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

27 дугаар зүйл. Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль тогтоомжийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

27.4. Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль тогтоомжийг зөрчсөнөөс бусдад учруулсан эд хөрөнгийн хохирлыг гэм буруутай этгээдээр зохих хууль тогтоомжийн дагуу нөхөн төлүүлэхийг сонирхогч этгээд нэхэмжлэх эрхтэй.

27.1. Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль тогтоомжийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч болон стандартын хяналтын улсын байцаагч дор дурдсан шийтгэл ногдуулна:

27.5. Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд зохих хариуцлага хүлээлгэх тухай стандартын хяналтын улсын байцаагчийн шийдвэрийн талаар гарсан маргааныг шүүх шийдвэрлэнэ.

27.1.1. стандарт, тохирлын үнэлгээний төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээ, мэдүүлгийг хуурамчаар гаргасан, мэргэжлийн хяналтын улсын байцаагчаас өгсөн үүргийг хугацаанд нь биелүүлээгүй бол иргэнийг 20000-40000, албан тушаалтныг 50000-60000, аж ахуйн нэгж, байгууллагыг 200000-250000 төгрөгөөр торгох;

28 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

27.1.2. итгэмжлэгдсэн сорилтын лаборатори, баталгаажуулалт, техникийн хяналтын байгууллага нь тохирлын үнэлгээний үр дүнг зориуд

28.1. Энэ хуулийг 2003 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

СТАНДАРТЧИЛАЛ, ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1994 оны 12 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

тохирлын үнэлгээний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

2 дугаар зүйл. Энэ хуулийг Стандартчилал,

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.10.9, 15.10.10 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

2 дугаар зүйл. Энэ хуулийг Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль хүчин төгөлдөр

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15.5, 15.6 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

тохирлын үнэлгээний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

2 дугаар зүйл. Энэ хуулийг Стандартчилал,

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн "санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн" гэснийг "Стандартчиллын Үндэсний зөвлөл" гэж өөрчилсүгэй.

тохирлын үнэлгээний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

2 дугаар зүйл. Энэ хуулийг Стандартчилал,

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.3-ын "стандарт," гэснийг хассугай.

болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

2 дугаар зүйл. Энэ хуулийг Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль хүчин төгөлдөр



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хот байгуулалтын тухай хуулийн 13.1.2-ын "стандартыг" гэснийг хассугай. болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль хүчин төгөлдөр

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

ОРОН СУУЦНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Орон сууцны тухай хуулийн 7.1.2-ын "стандарт" гэснийг хассугай. болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль хүчин төгөлдөр

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүнсний тухай хуулийн 14.3-ын "стандартчилал, хэмжил зүйн төв", 15.2-ын "мэргэжлийн хяналтын" гэснийг "стандартчиллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны"; 15.1-ийн "Лабораторийн итгэмжлэл авсан хуулийн этгээд" гэснийг "Итгэмжлэгдсэн сорилтын лаборатори, баталгаажуулалт, техникийн хяналтын байгууллага" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Хүнсний тухай хуулийн 13.1.5-ыг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтын "чанарын асуудал эрхэлсэн байгууллагын олгосон эрх бүхий лабораториос" гэснийг "Стандартчиллын төв болон түүнээс эрх авсан баталгаажуулалтын байгууллага" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

ХЭМЖЛИЙН НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл, хэсэг нэмсүгэй:

1/2¹ дүгээр зүйл:

"2¹ дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно:

1/ "хэмжил" гэж хэмжигдэхүүний утгыг тодорхойлох үйл ажиллагааг;

2/ "хэмжлийн нэгдмэл байдал" гэж хууль ёсны нэгжээр илэрхийлсэн хэмжлийн үр дүнгийн алдаа нь тогтоосон хязгаарт байгаа хэмжлийн үзүүлэлтийг;

3/ "загварын туршилт" гэж хэмжих хэрэгслийн загвар нь тогтоосон шаардлагад тохирч байгааг шалгах туршилтыг;

4/ "хэмжих хэрэгслийн баталгаажуулалт" гэж тухайн хэмжих хэрэгсэл нь тогтоосон шаардлагад нийцэж байгааг эрх бүхий хэмжил зүйн байгууллагаас тогтоож, батлах ажиллагааг;

5/ "шалгалт тохируулга" гэж хэмжих хэрэгслийн алдааны утгыг тогтоох ажиллагааг."

2/7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"4. Хэмжил зүйн төрийн хяналт шалгалтыг дараахь хэлбэрээр гүйцэтгэнэ:

1/ савласан бүтээгдэхүүний тоон хэмжээг хянах;

2/ хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих."

3/9 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг:

"9. Загварын туршилт хийлгээгүй хэмжих хэрэгслийг баталгаажуулалтад хамруулахгүй."

4/10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2. Тусгай зөвшөөрөлтэйгээр суурилуулах

хэмжих хэрэгслийн жагсаалтыг хэмжил зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

5/10¹ дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг

1. Хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, суурилуулах, засварлах, худалдах үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай¹ хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна дараахь баримт бичгийг бүрдүүлж Хэмжил зүйн төв байгууллагад ирүүлнэ:

1/ үйлдвэрлэх, суурилуулах, засварлах, худалдах хэмжих хэрэгслийн нэр төрөл, хэмжил зүйн үзүүлэлт, нарийвчлалын анги, загварын туршилтын гэрчилгээ, ашиглалтын баримт бичиг;

2/ ажлын байрны орчны тодорхойлолт, мэргэжлийн боловсон хүчин, эталон хэмжих хэрэгсэл болон тоног төхөөрөмжийн хангалт, тэдгээрийн хэмжил зүйн үзүүлэлт, ажил үйлчилгээнд мөрдөх технологийн заавар, стандарт.

2 дугаар зүйл. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 1 дүгээр зүйл, 12 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 6 дэх хэсгийн 3, 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтын "үйлдвэрлэх", 18 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 1 дэх заалтын "ашиглах," гэсний дараа "суурилуулах,"; 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "...төрийн өмч" гэсний дараа "бөгөөд төрийн хамгаалалтад", 8 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "...бүртгэнэ." гэсний дараа "Үйлдвэрлэгч орны хэмжил зүйн байгууллагаас олгосон загварын туршилт, анхдагч баталгаажуулалтын үр дүнг үндэсний хэмжил зүйн байгууллага хооронд байгуулсан хэлэлцээрийн үндсэн дээр хүлээн зөвшөөрч болно."; 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн гарчиг, 10 дугаар зүйлийн 1, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 6, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын "...үйлдвэрлэл," гэсний дараа "суурилуулалт,"; 10 дугаар зүйлийн гарчгийн "эрхлэх", 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Хэмжил зүйн төв байгууллагаас", 18 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 3 дахь заалтын "ажил, үйлчилгээ эрхлэх", 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын "ажил, үйлчилгээ эрхлэхэд", мөн зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтын "худалдах" гэсний дараа

¹ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль-Төрийн мэдээлэл эмхтгэлийн 2001 оны 6 дугаарт нийтлэгдсэн



заалтын "ажлын эталон" гэсний дараа "бий болгох"; 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "өөрийн төлбөрт" гэсний дараа "болон гэрээт"; 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын "хэмжих хэрэгсэл ашигласан" гэсний дараа "иргэнийг 10000-20000, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-150000 төгрөгөөр" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Хэмжил зүйн төрийн хяналт шалгалтыг дараахь хэлбэрээр гүйцэтгэнэ" гэснийг "Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах үйл ажиллагааг дараахь хэлбэрээр гүйцэтгэнэ"; 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "Баталгаажуулалт, тохируулгын" гэснийг "Баталгаажуулалтын"; 9 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн "ашиглах, бусдад хэрэглүүлэхийг" гэснийг "ашиглахыг"; 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Хэмжилзүйн төв буюу аймаг, нийслэлийн хэмжилзүйн байгууллагаас тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авна" гэснийг "Итгэмжлэлийн байгууллагаар итгэмжлэгдсэн байна."; мөн зүйлийн 3 дахь хэсгийн "Шалгалт тохируулга хийх зөвшөөрөл бүхий" гэснийг "Шалгалт тохируулга хийхээр итгэмжлэгдсэн"; мөн зүйлийн 5 дахь хэсгийн "Зөвшөөрөл бүхий" гэснийг "Итгэмжлэгдсэн"; 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтын "...тохируулга хийх, тэдгээрт баталгаажуулалт, тохируулга хийх зөвшөөрлийг холбогдох мэргэжлийн байгууллагад олгох" гэснийг "хийх"; мөн зүйлийн 2 дахь хэсгийн 6 дахь заалтын "болон шалгалт тохируулга хийх" гэснийг "тусгай"; 16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "олон нийт", 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Олон нийтийн" гэснийг "төрийн бус"; 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "...үнэн зөв, нэгдмэл байдлыг хангаж, хэмжил зүйн төрийн хяналт, шалгалтыг" гэснийг "хэмжлийн нэгдмэл байдлыг хангах үйл ажиллагааг"; 18 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 3 дахь заалтын "худалдах, бусдад хэрэглүүлэхдээ" гэснийг "худалдахдаа"; 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтын "11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт" гэснийг "11 дүгээр зүйлд"; мөн зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын "зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн" гэснийг "тусгай зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2, 8 дугаар зүйлийн 2, 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2. Дараахь үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгсэл, хэмжил гүйцэтгэх аргачлалыг хэмжил зүйн төрийн хяналт шалгалтад хамруулна:

- 1/ худалдаа, үйлчилгээний тооцоо;
- 2/ хун, мал эмнэлгийн шинжилгээ, эмчилгээ, оношлогоо;
- 3/ байгаль орчны хамгаалал;
- 4/ улсыг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах."

2/ 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2. Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх буюу импортоор нийлүүлэх аж ахуйн нэгж, байгууллага, импортоор нийлүүлэх иргэн тухайн хэмжих хэрэгслийн загварыг зохио норматив-техникийн болон ашиглалтын баримт бичгийн хамт Хэмжил зүйн төв байгууллагад ирүүлэн туршилт хийлгэж баталгаажуулна."

3/ 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын ажлыг Хэмжил зүйн төв болон аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллага эрхэлнэ. Итгэмжлэлийн байгууллагаар итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллага баталгаажуулалтыг гүйцэтгэж болно."

4/ 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт:

"1/ хэмжлийн нэгдмэл байдлыг хангах талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх;"

5 дугаар зүйл. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "хэмжил зүйн төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх", 17 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 3 дахь заалтын "засвар, тохируулга", 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5", "17 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 4", 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын "иргэнийг 5000-15000 төгрөгөөр," мөн зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын "14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт" гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалт, 17 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 4 дэх заалт, 18 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсон тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.10.8-ын "хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх," гэсний дараа "суурилуулах," гэж нэмсүгэй.

нэгдмэл байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хэмжлийн

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2003 оны 5 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 16

Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого батлах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

баталсугай.

"Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого"-ыг хавсралтын ёсоор

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

Улсын Их Хурлын 2003 оны 16 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл.

орчин бүрдүүлэх, тодорхой мэргэжлийн хүмүүсийг гэр бүлийн асуудлаар мэргэшүүлж ажиллуулах нь энэхүү бодлогын үндсэн зорилт болно.

1. Гэр бүл нь хүний хөгжлийн анхдагч орчин, нийгмийн үндсэн нэгж, соёл, уламжлал өвлөгдөн шинэчлэгдэх, аж төрөх ёсны бичил ахуй мөн.

2. Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлогын эрхэм зорилго нь гэр бүлийн амьдралын түвшинг тасралтгүй дээшлүүлж, гэр бүлийн харилцаа, ёс зүйн эрүүл орчин, түүний нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх замаар монгол хүний хөгжлийг дэмжихэд оршино.

3. Гэр бүлийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийг дэмжих, гэр бүлийн хөгжил, үр хүүхдээ асран хамгаалахад эцэг, эхийн жигд оролцоог хангах, гэр бүлээрээ амьдрахад нь туслах орон сууцтай болохыг дэмжих, гэр бүлийн өмчийн харилцаанд гишүүн бүрийг эрх тэгш оролцуулах, хүн амын эмзэг бүлгийн нийгмийн халамж, хамгааллын арга хэмжээг гэр бүлд төвлөрүүлэх, гэр бүлд зориулсан үйлчилгээний сүлжээг бий болгох, гэр бүлийн гишүүнийг хүчирхийлэх, эрхийг нь зөрчих явдлыг тууштай бууруулах эрх зүй, зан үйлийн зэрэг

4. Энэхүү бодлого нь ойрын 10-15 жилийн хугацаанд гэр бүлийн хөгжлийн хэтийн чиглэлийг тодорхойлох үндсэн баримт бичиг мөн.

Хоёр. Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлогын үндсэн зарчим

1. Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого /цаашид "гэр бүлийн хөгжлийн бодлого" гэх/-ыг хэрэгжүүлэхэд дараахь үндсэн зарчмыг баримтална:

1/гэр бүлийг хөрөнгө чинээ, алдар хүнд, үндэс, угсаа, амьдарч байгаа газар, нутаг, гишүүдийн арьс өнгө, эрхэлж буй албан тушаал, шашин шүтлэг, боловсролын түвшин зэргээс хамаарч ялгаварлан гадуурхагдах явдлаас ангид байлгах;

2/гэр бүлийн харилцаанд жендерийн



болон гэр бүлийн гишүүдийн тэгш эрхийг хангаж, бие даасан байдлыг хүндэтгэх;

3/гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийг дэмжиж, нөхөн үржихүйн эрхийг хүндэтгэх;

4/гэр бүлийн аюулгүй байдал, амар амгалан амьдрах эрхийг хангах;

5/гэр бүлийн хүрээнд үндэсний дэвшилтэт уламжлалыг дээдлэх;

6/боловсрол, эрүүл мэндийн зардлын өөрчлөлтийг ерхийн орлогын түвшинтэй уялдуулсан төрийн зохицуулалтын бодлого явуулах.

Гурав. Гэр бүлийн хөгжлийн бодлогын үндсэн чиглэл

1. Гэр бүлийн хөгжлийн бодлогыг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ:

1/гэр бүлийн харилцаанд гарч буй өөрчлөлт, амьдралын хэв маягийн дэвшилтэт талыг судалж, сөрөг үр дагаврыг арилгах, эерэг үр дүнг дэмжин дэлгэрүүлэх зорилгоор гэр бүл судлалыг хөгжүүлэх;

2/гэр бүлийг бэхжүүлэх эрх зүй, эдийн засаг, дэвшилтэт уламжлал, зан заншлыг өвлүүлэх орчинг бүрдүүлэх;

3/гэр бүлийн харилцаанд жендерийн тэгш байдлыг хангаж, эцэг, эх, нөхөр, эхнэрийн нэр хүнд, гэр бүлийн бусад гишүүддээ хандах хандлага, боловсролыг дээшлүүлэх;

4/гэр бүлийн харилцааны эрх зүйн орчин боловсронгуй болгож, хүүхэд, эмэгтэйчүүд, ахмад настны эсрэг хүчирхийллийг таслан зогсоох;

5/хөдөөгийн гэр бүлд орчин цагийн соёл, нийгмийн үйлчилгээг хүргэж, амьжиргааг дээшлүүлэх;

6/ залуу гэр бүлийг дэмжих орчин бүрдүүлэх;

7/гэр бүлд нийгмийн цогц үйлчилгээг хүргэж, эрүүл аж төрөх ёс, боловсрол, эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа бие даан явуулдаг зан үйлийг хэвшүүлэхэд туслах, нийгмийн халамжийн үйлчилгээг ойртуулах;

8/амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой буюу орлогын эх үүсвэргүй гэр

бүлийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;

9/хүн амын эмзэг бүлэгт үзүүлэх нийгмийн халамж, хамгааллын арга хэмжээг гэр бүлд төвлөрүүлэх;

10/хүүхдийг эрүүл чийрэг өсгөн бойжуулах, боловсрол эзэмшүүлэх, амьдрал, хөдөлмөрт бэлтгэх гэр бүлийн таатай орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Дөрөв. Гэр бүлийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх арга зам

1. Гэр бүл судлалыг хөгжүүлнэ:

1/монгол гэр бүл судлалыг хөгжүүлж, эрдэм шинжилгээний төслийн хүрээнд гэр бүлийн уламжлал, шинэчлэл, эрх зүй, социологи, боловсрол, аж ахуй эрхлэлт, сэтгэл зүй, ёс зүйн хөгжил, нийгмийн эрүүл мэнд, жендер зэрэг чиглэлээр судалгааг цогц байдлаар явуулж, үр дүнг төрийн бодлогод тусгаж хэрэгжүүлэх;

2/гэр бүл судлал, гэр бүлийн асуудлаар мэргэшсэн цагдаа, өмгөөлөгч, шүүгч, эдийн засагч, социологч, сэтгэл зүйч-багш, нийгмийн ажилтныг бэлтгэж ажиллуулах;

3/гэр бүлийн холбогдолтой бүхий л асуудлаар мэдээллийн тогтолцоо бүрдүүлэх;

4/гэр бүлийн хөгжлийг дэмжих ажлын хүрээнд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд олон улсын байгууллага, сонирхогч талуудтай хамтран ажиллах.

2. Гэр бүлийн ёс суртахуун, дэвшилтэт уламжлалыг дээдлэнэ:

1/гэр бүлийн гишүүд нэр төрөө эрхэмлэх, үүрэг, хариуцлагаа ухамсарлах, нинжин сэтгэл, хүний мөс, хүнлэг чанар, шударга ёс зэрэг нийгмийн үнэт зүйлсийг төлөвшүүлэхэд төрийн бодлого чиглэх;

2/төрт ёсыг хүндэтгэж, эх хэл, үндэсний бичиг, соёл, төрөлх нутаг, байгаль орчноо хамгаалж, өрх гэрийн ёс, өв уламжлал, үнэт зүйлийг эрхэмлэдэг гэр бүлийг бий болгох, хөдөлмөрийг шүтэж амьдрах орчинг төлөвшүүлэхэд төрөөс бүх талын дэмжлэг үзүүлэх;



3/удмынхаа нэр төрийг дээдлэх, угийн бичгээ хөтлөх, ахмадаа хүндлэх, жирэмсэн эхийг энэрэх, үр хүүхдээ амьдрал, хөдөлмөрт бэлтгэх зэрэг өвөг дээдсийн сайн үлгэр дууриаллыг өвлүүлэх үйл ажиллагааг дэмжих;

4/гэр бүлийн дотоод зөрчил, сэтгэл зүйн хямралаас гарах, маргааныг эв эеээр шийдвэрлэхийг эрмэлзэхэд туслах зорилгоор гэр бүлийн боловсролыг бүх шатны албан ба албан бус сургалтаар олгох;

5/бүх нийтийн гэр бүлийн боловсролыг дээшлүүлэхийн тулд телевиз, радиогийн нэвтрүүлэг, нийтлэлийг төрийн ивээл дор тогтмол явуулах;

6/гэр бүл нь хүүхдэд үндэсний дэвшилтэт ёс заншил, уламжлалаа дээдлэх хандлагыг төлөвшүүлэх, төрөлхийн гоц авьяас чадварыг нь нээн хөгжүүлэх ээлтэй орчин байх нөхцөлийг хангах;

7/гэр бүл бүртгэх ашгийн бус ордон, танхимыг аймаг, дүүрэг, сумын төвүүдэд нээж, гэрлэх ёслолыг ёс суртахуун, соёл уламжлалын баяр, хүний амьдралын ариун нандин үйл явдал болгон тэмдэглэж байх орчинг бүрдүүлэх.

3. Гэр бүлийн харилцаанд гендерийн тэгш байдлыг хангана:

1/эрэгтэйчүүд боловсролын түвшингээр хоцрогдож байгаа хандлагыг өөрчилж, үүнээс үүдэн гэр бүлийн харилцаанд үзүүлж байгаа сөрөг нөлөөг бууруулах;

2/ гэр бүлийн аж ахуйг хөтлөх, гишүүдийг асрах, сувилах, халамжлах, үйлчлэх зэрэг гэрийн хөдөлмөрийг нийгмийн зүгээс үнэлэх үнэлэмжийн таатай орчинг бүрдүүлэх;

3/ залуучуудад гэр бүлийн боловсрол эзэмшүүлж, гэр бүл, үр хүүхэд, эцэг эхийн өмнө хүлээх хариуцлагыг ухамсарлуулах чиглэлээр нийгмийн болон сэтгэл зүйн үйлчилгээг хөгжүүлэх;

4/гэр бүл төвтэй нийгмийн эрүүл мэнд болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх замаар хүн амын өсөлт, чанарыг сайжруулахад дөхөм үзүүлэх.

4. Гэр бүлийн харилцааны эрх зүйн орчинг

боловсронгуй болгоно:

1/гэр бүлийн гишүүдийн эрхийг зөрчих, дарамт шахалт үзүүлэх, хүчирхийлэх явдалтай тэмцэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох;

2/хүүхдийн эрхийг хамгаалах асуудлаар мэргэшсэн итгэмжлэгдсэн төлөөлөгч/омбудсмен/-ийг ажиллуулах;

3/гэр бүлийн маргааныг гэр бүлийн асуудлаар мэргэшсэн шүүгч шийдвэрлэдэг болох;

4/гэр бүлийн даатгалын эрх зүйн орчинг бүрдүүлж, тэтгэвэр, тэтгэмж болон эрүүл мэндийн даатгалд гэр бүлийн гишүүн бүрийг бүрэн хамруулах арга хэмжээг дэс дараатай авах.

5. Хөдөөгийн гэр бүлийг дэмжинэ:

1/хөдөөгийн гэр бүлийн мэдээллийн хүртээмж, ахуйн соёлыг нь сайжруулах санаачлагыг төрийн бодлогоор дэмжих;

2/сургууль завсардсан хүүхдүүд, хөдөөгийн залуучуудыг бичиг үсэгтэй болгох ажлыг албан бус, зайны сургалтаар явуулах нөхцөлийг гэр бүл бүрт бий болгох арга хэмжээ авах;

3/хөдөөгийн гэр бүлийг боловсрол, эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээгээр хангах, бүс нутгийн хөгжлийн бодлогын тулгамдсан асуудалтай холбоотой арга хэмжээг эхний ээлжинд хэрэгжүүлэх.

6. Залуу гэр бүлийг дэмжинэ:

1/залуу гэр бүлийг орон сууцтай болохыг дэмжих хөнгөлөлттэй, урт хугацаатай зээлийн сан, түрээс/лизинг/-ийн үйлчилгээ, оюутны гэр бүлийн хүүхдэд зориулсан сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллага хөгжүүлэх зэргээр залуу гэр бүлд нийгмийн таатай орчин бүрдүүлэх;

2/залуучуудын гэр бүлийн талаархи мэдлэг, ойлголт, хандлагыг судалж, уламжлал, шинэчлэлийн асуудлаар хэлэлцүүлэг, ярилцлага зохиох;

3/залуучууд, өсвөр үеийнхэнд бэлгийн амьдралын зохистой мэдлэг, соёл, зөв зан үйл төлөвшүүлэх;

4/залуучуудад бие дааж шийдвэр гаргах чадвар эзэмшүүлэх төсөл, шинээр гэр бүл бологсдод туслах зорилгоор гэргий болон өрхийн тэргүүнийг бэлтгэх сургалт зохион байгуулах ажлыг төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх.

7. Гэр бүлд чиглэсэн нийгмийн үйлчилгээг сайжруулна:

1/гэр бүлээрээ амьдрах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд орон сууцны хангамжийг сайжруулах бодлогыг гэр бүлийн орлого, хуримтлал, нийгмийн байдалд нь зохицуулан тогтмол хэрэгжүүлэх;

2/гэр бүлд чиглэгдсэн сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг хөгжүүлж, хууль зүй, сэтгэл зүй, өрхийн амьжиргаа, хүүхдийн хүмүүжил зэрэг сэдвээр биечлэн болон утсаар зөвлөлгөө өгөх үйлчилгээний сүлжээ бий болгох;

3/гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн гишүүдийг түр хамгаалах байр бий болгох, төлбөрийн чадвартай асран хамгаалах төрөл садангүй ахмад настан, хүүхдэд баталгаатай, төлбөртэй үйлчлэх төв зэрэг төрийн санхүүгийн дэмжлэг, хяналт бүхий өвөрмөц үйлчилгээний хэлбэрийг дэмжиж, иргэний нийгмийн бүлгүүдтэй нягт хамтран ажиллах;

4/нийгмийн халамж, хамгаалал шаардлагатай хүүхэд, ахмад настан, тахир дутуу иргэдэд халамжийн үйлчилгээг гэр бүл, нийгэм, хамт ололд түшиглэн үзүүлэх чиглэлийг баримтлах;

5/эмзэг бүлгийн гэр бүлийн гишүүдэд боловсрол олох, мэргэжил эзэмших сургалтанд хамрагдах, ажлын байраар хангагдах, өрхийн амьжиргааг дэмжих хөтөлбөр, төслийн арга хэмжээнд эхний ээлжинд хамрагдах боломжийг олгож, нийгэмшүүлэх, өөртөө итгэх итгэл, амьдрах арга ухаан олоход нь туслах;

6/гэр бүл дэх хөдөлмөрийн чадваргүй гишүүдийнхээ нийгмийн баталгааг хангах зорилгоор тэдний нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг өрхийн хөдөлмөрийн чадвартай гишүүд нь хариуцан төлөх тогтолцоог бий болгох;

7/өрхийн амьжиргааны чадамжийг дэмжих замаар ажил эрхлэлт, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж иргэдийг ядуурлаас хамгаалах, ядуурлыг бууруулах арга хэмжээ авах.

8/эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэх, гэр бүлийн гишүүдийн бие бялдрын хөгжлийг дэмжих үүднээс нийтийн биеийн тамир, спортын арга хэмжээг өргөжүүлэх, энэ талаархи хэвлэл, мэдээллийн сурталчилгааг нэмэгдүүлэх;

9/оюуны өндөр чадамж, гоц авьяастай хүүхэд, залуучуудыг хөрөнгө чинээнээс нь үл хамааран сургаж, хөгжүүлэх бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлэх;

10/30-аас дээш жил ханилсан үлгэр дууралтай эхнэр, нөхөр, үр хүүхдээ сайн иргэн болгож төлөвшүүлсэн эцэг, эхийг төрөөс хүндэтгэн урамшуулах.

Тав. Гэр бүлийн хөгжлийн бодлогын удирдлага, зохион байгуулалт

1. Улсын хэмжээнд гэр бүлийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг хүн ам зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна. Аймаг, нийслэлийн түвшинд хүн ам, гэр бүлийн асуудал хариуцсан хэлтэс, сум, дүүрэг, хороонд гэр бүлд туслах нийгмийн ажилтан ажиллуулна.

2. Гэр бүлийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх механизм:

1/гэр бүлийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгана;

2/бодлогыг хэрэгжүүлэх жил бүрийн төлөвлөгөөг хүн ам зүйн бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулан мөрдүүлнэ. Салбарын яамдын эрхлэх асуудалтай холбоотой бодлогыг тухайн яам хариуцахаар төлөвлөгөөнд тусгаж, гүйцэтгэлийн мэдээ, тайланг хүн ам зүйн бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд ирүүлнэ;

3/бодлогыг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр нь улсын болон орон нутгийн төсөв, дотоод, гадаадын хандивлагчдын тусламжаас бүрдэнэ.



2003 оны 5 дугаар сарын 15-ны өдөр

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

Дугаар 17

Улаанбаатар хот

Шуудангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.13-т заасныг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Шуудангийн тухай хууль батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасгай:

1/ шуудангийн төв, орон нутаг дахь салбар, нэгжүүдийг зориулалтын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, мэргэжлийн боловсон хүчнээр хангах зорилгоор Монгол Улсын шуудангийн салбарыг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх;

2/ шуудангийн үйлчилгээний шуурхай, найдвартай байдлыг хангахын тулд аймаг, нийслэл, сумын төвүүдэд шуудангийн үйлчилгээний зориулалтаар ашиглаж байгаа байрыг Монголшуудан компанийн эзэмшилд шилжүүлэх асуудлыг судалж, шийдвэрлэх;

3/ Монгол Улсын хагсийн нэгдсэн системийг шинэчлэн тогтоох;

4/ Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэмд өөрчлөлт оруулах замаар Зохицуулах хорооны бүтцэд шуудангийн асуудал эрхэлсэн алба байгуулж ажиллуулах;

5/ Шуудангийн тухай хуульд холбогдох эрх зүйн актуудыг нийцүүлэх;

6/ Шуудангийн тухай хуулийн 14.2-т заасан санхүүгийн үйлчилгээг үйлчлэгчээс эрхлэн явуулах боломж, холбогдох хууль тогтоомжийг судлан үзэж, тодорхой санал боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

Хөвр. Энэ тогтоолын 1-д заасан арга хэмжээг 2003 онд багтаан авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т үүрэг болгосгай.

Гурав. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Т.Очирхүү/-нд даалгасгай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

2003 оны 5 дугаар сарын 23-ны өдөр

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

Дугаар 18

Улаанбаатар хот

Үндсэн хуулийн цэцийн 2003 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 15.1.5; 15.1.6-д заасныг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 3-д заасан "энэ хуулийн 20.2; 38.9; 65.1.1; 65.1.3; 65.1.6-65.1.10 дахь ...зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гомдол гаргахгүй" гэсэн заалт, Прокурорын байгууллагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1-д заасан "...өмгөөлөгчийн бүрэн эрх эдэлнэ", мөн хуулийн 16 дугаар зүйлийн 2-д заасан "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн ... 34 дүгээр зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээн" гэсэн заалтууд Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-д заасан "Монгол Улсын иргэн...шударга шүүхээр шүүлгэх, ...шүүхийн шийдвэрийг давж заалдах...эрхтэй" гэсэн заалт, Тавин зургадугаар зүйлийн заалтыг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2003 оны 01 дүгээр дүгнэлтийн холбогдох заалтыг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65.1.1-д заасан "шүүхэд харьяалагдахгүй", 65.1.6-д заасан "...эсхүл нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан...", 170.3-

д заасан "энэ хуулийн ...74, 75, 76 дугаар зүйл, 106.5; 129, 130 дугаар зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид зохигч гомдол гаргахгүй", 31.1-д заасан "прокурор төрийн ашиг сонирхол эерчигдсэн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно" гэсэн заалтууд, Прокурорын байгууллагын тухай хуулийн 16.6-д заасан "Төрийн байгууллага хүсэлт гаргасан бол иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос прокурор татгалзах ёсгүй", 16.1-д заасан "Прокурор төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчийн төлөөлөгчөөр оролцоно..." гэсэн заалт, мөн зүйлийн 2-д заасан "Прокурор энэ хуулийн 16.1-д заасан ажиллагаанд оролцохдоо иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ" гэсэн заалтууд нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг тус тус зөрчөөгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2003 оны 01 дүгээр дүгнэлтийн холбогдох заалтыг хүлээн зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн өвөлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хөлхөл хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

Хөвгөлийн хуудас 3-5

☎ 329487